



МЕРСИ КОР МОНГОЛ ХӨГЖЛИЙГ БҮТЭЭЛЦСЭН ОН ЖИЛҮҮД

22 жилийн нэгдсэн тайлан

2021 ОНЫ 5 САР



МЕРСИ КОРЫН ДОНОР БОЛОН ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД

Донор байгууллагууд

Мерси Кор санхүүгийн дэмжлэг үзүүлсэн донор байгууллагуудын хувь нэмрийг өндөр үнэлж байгаа. Өнгөрсөн 22 жилийн хугацаанд Мерси Кор Монгол ОУБ нь донор байгууллагуудаас нийт 66 сая ам долларын санхүүжилт авч төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлсэн. Ялангуяа 22 жилийн турш 52 сая ам доллар буюу нийт санхүүжилтийн 70 гаруй хувийг гаргасан АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг болон Хөдөө Аж Ахуйн Департаментад талархлаа илэрхийлж байна.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг

АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департамент

Мерси Корын Глобал Сан

Швейцарын Хөгжлийн Агентлаг

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Гамшигт

Нэрвэгдсэн Гадаад Орнуудад Тусламж Үзүүлэх Газар

Монгол улсын Засгийн газар

Дэлхийн банк

Адвентурист

Техасын Хөдөө Аж Ахуйн Туршилтын Станц

Европын Иргэний Хамгаалал, Хүмүүнлэгийн Тусламжийн Байгууллага (ECHO)

Азийн Хөгжлийн Банк

Дэлхийн Хүнсний Хөтөлбөр (ДХХ)

Британийн Элчийн Сайдын Яам

Үндсэн түншүүд

Олон улсын болон монголын төрийн ба хувийн байгууллагуудтай хамтран Мерси Кор Монголын хөдөө орон нутагт тогтвортой өөрчлөлт авчирч чадсан. Төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд бидэнтэй хамтран ажилласан олон түнш байгууллагуудад талархлаа илэрхийлье.

Олон улсын байгууллагууд

Пакт

Лэнд О' Лэйкс

Азийн сан

Дэлхийн хүнсний хөтөлбөр

Хөдөөгийн хөгжлийн түншүүд

Пийпл-ин-Нийд (ПИН)

Техасын хөдөө аж ахуй механикийн Их сургууль

Хүнс хөдөө аж ахуйн байгууллага

Монголын хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагууд

Хөгжлийн шийдэл

ХААН банк

Монголын нутгийн удирдлагын холбоо

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ)

Монголын тэргэнцэртэй иргэдийн үндсэний холбоо

Худалдан авалтын хөгжлийн төв

Төрийн банк

ХасБанк

Бодлого судлалын төв

Мэдээлэл боловсролын төв

Хөгнө Мээж ТББ

Хушаатын хамтын хүч хоршоо

Кинг Консалтинг ХХК

Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв

Захиргааны шинэ санаачилга ТББ

Сац Манал мал эмнэлэг

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори

Түгээмэл хөгжил ТББ

Ви.И.Ти.Нет ТББ

Өмнөговь аймгийн Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн

Занаду Разорбак ХХК

Өвөрхангай аймгийн Орон нутгийн санаачлага ТББ

Монголын төрийн байгууллагууд

Монголын бүх шатны төр захиргааны байгууллагуудтай түншилж хамтран ажилласанаа өндөр үнэлж байна.

Авилгатай тэмцэх газар (АТГ)

Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ)

Худалдан авах ажиллагааны газар (ХААГ)

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хөдөө аж ахуйн Их сургууль (ХААИС)

Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)

Сангийн яамны худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс

Ерөнхийлөгчийн Тамгын газар

Боловсрол шинжлэх ухааны яам (БШҮЯ)

Цаг уур орчны шинжилгээний газар (ЦҮОШГ)

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн (МАНЭШХ)

Товчилсон үгс

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага	шинжлэх ухааны аргыг ашиглах төсөл	
БДҮ	Бизнесийг дэмжих үйлчилгээ	MSD	Зах зээлийн тогтолцоог хөгжүүлэх арга барил
БМТ	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө	NAMEM	Цаг уур орчны шинжилгээний газар (ЦУОШГ)
ДХХ	Дэлхийн хүнсний хөтөлбөр	PDS	Мал амьтны өвчнийг оролцооны аргаар тандан судлах
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр	RCP	Даван Туулах, Дасан Зохицох Чадвартай Орон Нутгийн Иргэд
ЗБГХ	Зээлийн баталгаа гаргах хөтөлбөр	SMS	гар утасны мессеж
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага	SSN	Нийгмийн хамгааллын сүлжээ төсөл
МАА	Мал аж ахуй		
МААЭУМТ	Мал аж ахуйн эрсдлийг урьдчилан мэдээлэх тогтолцоо		
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар		
МКМ	Мерси Кор Монгол		
МХБИНХ	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо		
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага		
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар		
ТАН	Сургалт, нөлөөлөл ба хамтын ажиллагааны сүлжээ		
ТББ	Төрийн бус байгууллага		
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл		
ТҮХ	Тендерийг үнэлэх хороонд		
ҮСХ	Үндэсний статистикийн хороо		
ҮӨБ	Үйлдвэрлэгчдийн өргөтгөсөн бүлэг		
ХАА	Хөдөө аж ахуй		
ХААИС	Хөдөө аж ахуйн Их сургууль		
ХАБДХ	Хөдөөгийн агробизнесийг дэмжих хөтөлбөр		
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн		
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам		
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани		
ХХААБ	Хүнс хөдөө аж ахуйн байгууллага		
ОУХА	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг		
ШХА	Швейцарын Хөгжлийн Агентлаг		
ЦУОШГ	Цаг уур орчны шинжилгээний газар		
ARPEAL	Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо төсөл		
BRICS	Засаглалын хариуцлагатай байдлыг сайжруулах төсөл		
FIELD	Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх төсөл		
ICOGS	Төрийн худалдан авах ажиллагааны ил тод өрсөлдөөнт тогтолцоог бэхжүүлэх төсөл		
LEGS	Мал сүрэгт тохиолдсон онцгой байдлын үед баримтлах заавар болон стандартууд		
LTS	Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон		



Фото зураг: Тэтчер Куук (2001)

Зуд

Их хэмжээний цас орж малын бэлчээр цасанд дарагдах, удаан хугацаагаар огцом хүйтрэх, хүйтэн цасан шуурга олон хоногоор үргэлжлэн мал сүрэг бэлчээргүйдэн өлдөх, даарах зэргээс турж эцэн олноор хорогдохыг зуд гэж ойлгоно.

Монгол нь далай тэнгисээс ихээхэн алслагдан оршдог, хур тунадас багатай, эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай орон юм. Энэ нь ган зуд болоход нөлөөлдөг юм. Томоохон ган зуд Монголд арван жилд 1-2 удаа тохиолддог. Цаг уурын өөрчлөлт, бэлчээрийн доройтлын улмаас сүүлийн жилүүдэд ган зудын давтамж нэмэгдэж байгаа. 1999-2002 онд Монгол 3 удаа дараалж ган зуданд нэрвэгдэж, малын тоо улсын хэмжээнд 30%-иар хорогдсон. 2009-2010 оны зуднаар нийт малын 26% хорогдсон билээ.*

* Sternberg, T. Investigating the presumed causal links between drought and dzud in Mongolia. Nat Hazards 92, 27–43 (2018). <https://doi.org/10.1007/s11069-017-2848-9>

Монгол улс 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас ардчилсан нийгэм, чөлөөт зах зээлийн эдийн засаг руу шилжиж эхэлсэн. Хэдийгээр энэ өөрчлөлт тайван замаар бий болсон ч ардчилсан засаглал, эдийн засгийн шинэ тогтолцоо руу шилжих явцад Монголчууд олон саад бэрхшээлтэй тулгарсан. Олон мянган иргэд хувийн бизнес эрхэлж эхэлсэн энэ өрсөлдөөнтэй шинэ нөхцөл байдалд уламжлалт амьдралын хэв маягаа хадгалах, эдийн засгийн шинэ орчин нөхцөлд дасах шаардлага гарч ирсэн. Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбар орон нутгийн иргэдийн амьжиргааны гол эх үсвэр болдог бөгөөд малчид нэмүү өртгийн сүлжээний чухал хэсэг юм. Хөдөөгийн малчдад чөлөөт зах зээлийн тогтолцоонд бизнесийн мэдлэг, ур чадвараа сайжруулах шаардлага тулгарсан.

Мерси Кор Монгол (МКМ) ОУБ нь 1999 онд байгуулагдсан бөгөөд хамгийн анхны хэрэгжүүлсэн төсөл нь Говийн Бүсийн Эдийн Засгийг Хөгжүүлэх Санаачилга буюу Говийн Санаачилга төсөл байлаа. Нийгмийн хамгааллын тогтолцоо нь төдийлөн сайн хөгжөөгүй, далд эдийн засагтай, эрс тэс уур амьсгалтай, бэлчээрийн доройтолд нэрвэгдсэн, сул засаглалтай хэврэг орчинд уламжлалт мал аж ахуйгаа түшиглэн аж төрж буй иргэд зах зээл рүү шилжих явцад эдийн засаг, нийгэм, байгаль орчны олон асуудалтай тулгарч эхэлсэн юм. Говийн Санаачилга төсөл нь Монголчуудтай хамтарч зах зээлийн тогтолцоог хөгжүүлэх аргаар орон нутгийн иргэдийн хямрал, бэрхшээлийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд анхаарал хандуулсан билээ.

Бид Монгол дахь үйл ажиллагаагаа дуусгаж байгаатай холбогдуулан, 22 жилийн дотор олсон ололт амжилт, үр дүнгээ энэхүү тайланд товч толилуулж байна. МКМ нь хариуцлага бүхий түншлэл дээр тулгуурлан хөдөө орон нутгийг хөгжүүлэхийг зорьж, иргэдийн эмзэг байдлыг бууруулах, эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэж ирсэн билээ. МКМ нь хөдөөгийн иргэдэд уламжлалт аргыг орчин үеийн арга барилтай хослуулан хөгжихөд дэмжлэг үзүүлсэн. Тогтвортой, чадавхтай төрийн болон хувийн хэвшлийн институцудыг бэхжүүлсэн Монгол улс цаашид эрч хүчтэй эдийн засаг руу тэмүүлэхэд нэгэнт бэлэн болжээ.

“Мерси Кор ОУБ Монголд ажиллах хугацаанд төсөл хөтөлбөртөө хөдөө орон нутгийн иргэдийн оролцоог хангахыг чин сэтгэлээсээ хичээсэн билээ. Бидний үүрэг бол Монголын бүх түвшний оролцогч талуудын ажлыг дэмжиж, туслахад оршиж байсан.

Бид иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн ийм хүчтэй байгууллагуудтай олон жилийн турш хамтран Монгол улсад тулгараад буй зарим асуудлуудыг шийдвэрлэж ирсэндээ маш их баяртай байна”.

Вэнди Гайет,

Мерси Кор байгууллагын Монгол дахь Суурин төлөөлөгч, 2018-2021 он

МЕРСИ КОРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Мерси Кор нь Монголын төр болон хувийн хэвшилтэй хамтран хөдөөгийн иргэдийн эмзэг байдлыг бууруулж, эдийн засгийн боломжуудыг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжиж ирсэн.

Хугацаа: 1999 оны 1 сараас 2021 оны 6 сар

Санхүүжилт: 26 хөтөлбөрт 66 113 005 ам.доллар зарцуулав.

Хамрах хүрээ: Улаанбаатар дахь төв оффист байрлаж, Монгол улсын бүх аймагт хөтөлбөрүүдээ хэрэгжүүлсэн.

Үр нөлөө: Амьжиргаа, гамшгийн эрсдэлийн менежмент, сайн засаглалыг сайжруулах замаар хөдөөгийн Монголчуудын эмзэг байдал буурч, эдийн засгийн боломжууд нэмэгдсэн.

Онцлох үйл явдлууд:

147 000 гаруй малчин, фермер, малын эмч, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчид орон нутгийн амьжиргааг дээшлүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээнд хамрагдаж, үр шим хүртсэн.

ЖДҮ, бизнес эрхлэгчид, малчдад бизнесээ хөгжүүлэх, өргөжүүлэхэд зориулж **44 мянга** гаруй зээлийг банк, бичил санхүүгийн байгууллагуудаар дамжуулан олгов.

21 аймгийн 330 сумын төлөөлөгчид цаг агаар болон бэлчээрийн менежментийг сайжруулж, гамшгаас хамгаалахад туслах зорилготой мал аж ахуйн эрсдлийг урьдчилан мэдээлэх (МАЗЭУМТ) системийг ашиглаж сурсан. Бараг 10 гаруй жилийн дараа ОБЕГ-тай хамтран “Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар, стандартууд” (LEGS) сургалтыг зохион байгуулж, LEGS-ын дагуу сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулсан.

Улсын хэмжээнд **40 гаруй мянган гар утасны хэрэглэгч** 200 гаруй мянган мессежээр цаг агаар, бэлчээрийн мэдээлэл авч, гамшгийн төлөвлөгөө боловсруулах чадвараа дээшлүүлсэн.

Төр, иргэний нийгмийн нээлттэй, хариуцлагатай, хүртээмжтэй орчин бүрдүүлэх зорилгоор 60 гаруй ИНБ-уудад жижиг тэтгэлэг олгосны үр дүнд **250 гаруй мянган иргэн** үр шим хүртсэн.

310 гаруй ИНБ сургалтанд хамрагдаж, төрийн байгууллагууд, иргэдтэй хамтран ажиллах байгууллагын үр чадвараа бэхжүүлсэн.



Фото зураг: Шон Шеридан (2017)





ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Нар жаргах бүрд шинэ өдөр ирдэг. Харин МКМ-ын түнш, оролцогч талуудын хувьд ирээдүй маш тод гэрэлтэн харагдаж байна. Манай байгууллага хорин жилийн турш шинэлэг, үр өгөөжтэй хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлсний эцэст Монгол дахь үйл ажиллагаагаа хаах шийдвэр гаргалаа. Монголын ирээдүй улам илүү гэрэл гэгээтэй харагдаж байна.

1999 онд буюу Монгол улс чөлөөт зах зээл, ардчилсан нийгэм рүү шилжиж байх үед Мерси Кор үйл ажиллагаагаа Монголд анх эхлүүлж, ирээдүйг харсан шинэ бодлого стратегийг зоригтойгоор нэвтрүүлсэн билээ. Мерси Корын зах зээлийн тогтолцоог хөгжүүлэх аргыг туршсан анхны улс орнуудын нэг нь Монгол улс болсон - энэ бол хөгжлийн салбарт анх удаа хэрэгжсэн зүйл гэж хэлж болно. Түүнээс хойш бид энэ шинэ бодлогоо бусад улс оронд амжилттай хэрэгжүүлсэн.

Жишээ нь Монголд анх хэрэгжүүлсэн бизнес эрхлэгчдэд зээл авах боломжийг нэмэгдүүлсэн хөтөлбөрийг Мерси Кор бусад олон улс оронд амжилттай нэвтрүүлсэн. Бид Говийн Эхлэл ХХК-ын амжилт дээр тулгуурлан, улс даяар бичил санхүүгийн үйлчилгээгээ өргөжүүлэх шийдвэр гаргаж, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран ХасБанкийг үүсгэн байгуулсан. Тухайн үед Монгол улсын банкны салбар өөрчлөлт хийхэд бэлэн байсан бөгөөд бидний энэ зоригтой алхам нь иргэдийн боломжуудыг нэмэгдүүлсэн билээ. ХасБанк байгуулсан сургамж, туршлага дээрээ түшиглэн 20 жилийн хугацаанд МКМ эмзэг бүлгийн иргэдэд зориулсан бичил банк санхүүгийн үйлчилгээг дэмждэг дэлхийн шилдэг байгууллага болж чадсан.

Мерси Кор 40 гаруй төслийг Монголын бүх аймагт хэрэгжүүлж, нийт 60 гаруй сая америк долларын тусламж үзүүлсэн юм. Бид хөтөлбөртөө инноваци, нөлөөлөл, үр нөлөө, хэрэгжилт зэрэг дөрвөн зарчмыг байнга баримталж ирсэн. Жишээ нь:

- › Инноваци: малчид, хөдөөгийн иргэдэд зориулсан гар утасны мессежээр (SMS систем) цаг агаарын мэдээ түгээх системийг бий болгож, ОБЕГ-д хүлээлгэн өгсөн.
- › Нөлөөлөл: олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Малын өвчнийг оролцооны аргаар тандан судлах” аргыг Монголын мал амьтны эрүүл мэндийн тандан судалгааны тогтолцоонд нэвтрүүлэв.
- › Үр нөлөө: LEGS сургалтын тоог нэмэгдүүлж, гамшгийн төлөвлөлтийн хүрээг улс даяар өргөжүүлэв.
- › Хэрэгжилт: манай ажилтнууд эрс тэс цаг уур, хатуу ширүүн нөхцөлд хол замд аялж хөтөлбөрүүдээ хэрэгжүүлсэн.

Олон улсын хөгжлийн салбарт даван туулах дасан зохицох аргачлал дөнгөж нэвтэрч байх үед МКМ түншлэлд суурилсан цогц арга барилаар ажиллаж эхэлсэн. Өнөөдөр бид Монголд эхлүүлсэн иргэдийн эмзэг байдлыг бууруулах, эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх ажлаа үргэлжлүүлж, дэлхий даяар иргэдтэй хамтран ажиллах замаар үргэлжлүүлж байна.

Энэ бол бид бүгдийн амжилт. Бүх түнш байгууллагууд, манай багийн гишүүд, оролцогч талууддаа баяр хүргэе. Ирэх өдөр бүр гэрэлтэй байна.

Хүндэтгэсэн,

Жада Д'Оен МакКенна
Ерөнхий Захирал
Мерси Кор Глобал

ГАДААД ОРЧИНД

1999-2001 он. Монгол улсад гурван жил дараалан зуд болсон нь малчдад маш хүндээр тусаж, олон малчин өрх малаа алдаж, амьжиргааны эх үүсвэргүй болсон. 1999-2001 оны хооронд улсын нийт малын 35% ган, зудын улмаас хорогджээ.

2008 он. Дэлхийн санхүүгийн хямралын улмаас Монголын эдийн засаг уналтанд орсон.

2009 он. Монголын Засгийн газар Рио Тинто компанитай өмнийн говьд дэлхийд томоохон уурхайн нэг болох Оюу Толгойн алт зэсийн уурхай байгуулах гэрээнд гарын үсэг зурж, олон улсын хөрөнгө оруулалтыг татан, олон мянган ажлын байр бий болгож, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулав.

2010 он. Монгол улсад зудын гамшиг нүүрлэж, малын тоо толгой 26%-аар хорогдов. Малын тоо толгой 2009 онд 44 сая байснаас 2010 онд 32.7 сая болж буурчээ.

МЕРСИ КОРЫН ГҮЙЦЭТГЭСЭН ГОЛ АЖЛУУД

1999

МКМ таван жилийн хугацаатай Говийн Бүсийн Эдийн Засгийг Хөгжүүлэх Санаачилга буюу Говийн Санаачилга төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

Говийн Бизнес Мэдээ сэтгүүл байгуулагдаж, үндэсний болон орон нутгийн бизнес мэдээг англи, монгол хэл дээр түгээж эхлэв.

Орлоцооны аргаар орон нутгийн хөгжлийн зорилгыг тодорхойлох эдийн засгийн семинар аймгуудад зохион байгуулагдав.

2000

Хөдөөгийн бизнес эрхлэгчдэд бичил зээл олгох зорилготой Говийн Эхлэл ББСБ байгуулагдав.

2002

Орон нутгийн зөвлөх багш бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд “Сургагч багш бэлтгэх сургалт” зохион байгууллаа.

“Говийн бизнес мэдээ” сэтгүүл “Хөдөөгийн бизнес мэдээ” нэртэй болж, үндэсний хэмжээнд тогтмол хэвлэгддэг боллоо.

2001

Говийн Эхлэл ББСБ НҮБ-ын Хөгжлийн Алтан Сантай нэгдэн ХасБанк байгуулагдлаа.

Ноолуурын дуудлага худалдаанд малчид оролцож ноолуураа өндөр үнээр боловсруулагчдад борлуулсан.

2003

МКМ “Сургалт нөлөөлөл ба хамтын ажиллагааны сүлжээ” төсөл хэрэгжүүлж, засаглал сайжруулах чиглэлд ажиллаж эхлэв.

2004

Хөдөөгийн Агробизнесийг Дэмжих Хөтөлбөр (ХАБДХ) ба Говийн Санаачилга II төсөл арван аймагт хэрэгжиж эхлэв.

ХасБанк болон бусад арилжааны банктай хамтран хөдөөгийн бизнес эрхлэгчид, малчдад зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Зээлийн баталгаа гаргах хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн.

2007

Бизнесийг дэмжих үйлчилгээ өргөжиж, орон нутгийн зөвлөхүүдийг ажиллуулдаг болсон

Малчдын хоршоо бүлгүүд нэгдэж мал аж ахуйн түүхий эдийг борлуулах, үйлдвэрлэлд шаардлагатай орц нийлүүлэх зорилгоор “Малчны Альянс” байгуулав.

Бэлчээрийн төлөв байдлын зураг тогтмол гарч эхэллээ.

2005

МКМ Монголын анхны байгалийн эрсдлийг бууруулах Говийн Бэлчээр төслийг хэрэгжүүлж, Техасын Хөдөө аж ахуйн Их сургуультай хамтран анхны бэлчээрийн төлөв байдлын газрын зураг боловсруулан түгээлээ.

2006

Бэлчээрийн төлөв байдлын мэдээг радиогоор дамжуулж, малчдад өвлийн бэлтгэлээ базаахад тус болов.

2009

“Мал аж ахуйн эрсдлийг урьдчилан мэдээлэх тогтолцоо” төсөл (МАЗЭУМТ) нээлтээ хийж, МКМ бүх аймагт үйл ажиллагаагаа явуулах боллоо.

МКМ Монголд анх удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх” төсөл (FIELD) хэрэгжүүлж эхэллээ.

Малчны Альянс үйл ажиллагаагаа өргөжүүлж худалдах, худалдан авах гэрээний нөхцлөө сайжрууллаа

2010

Нөлөөллийн ажиллагааны үр дүнд иргэний барилга болон замын төлөвлөлтөнд ХБИ-ийн шаардлагыг тооцсон орон зай орчны заавар стандартууд батлагдлаа.

Хөтөлбөрийн үндсэн чиглэлүүд

- Эдийн засгийн хөгжил
- Гамшигийн эрсдэлийг бууруулах
- Сайн засаглал

Мерси Кор Монгол Он цагийн түүхэн Товчоон 1999-2021



2011 он. Худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ИНБ-ууд төрийн худалдан авалтад оролцох боломжтой болов.

2012 он. МКМ-ын хэрэгжүүлсэн олон нийтийн ойлголт мэдлэг дээшлүүлэх аян, нөлөөллийн үр дүнд Засгийн газар ХБИ-д зориулсан хүртээмжтэй орчин бий болгох шийдвэр гаргалаа

2018 он. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль хэрэгжиж эхэллээ; Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ) байгуулагдав.

2020 он. Монголд COVID-19 цар тахал гарч, иргэдийн эрүүл мэнд, амьжиргаа, хөгжилд сөргөөр нөлөөлөв.

2021 он. COVID-19-н дархлаажуулалтын аян эхлэв. Ерөнхийлөгчийн сонгуулийн тов гарлаа.

2011

Хүнсний аюулгүй байдлын үндэсний анхны форум зохион байгуулагдаж, мал аж ахуйн салбар дахь эрүүл мэнд, ариун цэврийн талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлээ.

Зуданд нэрвэгдсэн айл өрхүүд нийгэм-сэтгэл зүйн сургалтад хамрагдлаа.

2013

Төрийн байгууллагууд худалдан авах ажиллагааны дүрэм, худалдан авах бараа үйлчилгээний жагсаалтаа нийтэллээ

“Сайн засаглалын долоо хоног” арга хэмжээ зохион байгуулагдаж, сайн засаглалыг дэмжих, авилгыг бууруулах ажилд иргэдийн анхаарлыг хандууллаа.

2012

“Төрийн худалдан авах ажиллагааны ил тод өрсөлдөөнт тогтолцоог бэхжүүлэх” (ICOGS) төсөл хэрэгжиж эхэллээ.

Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар Авлигын эсрэг төлөвлөгөөний чанарыг дээшлүүлээ.

2014

Иргэдийн оролцоон дээр суурилсан Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлав.

Зудыг давах шилдэг туршлага, уламжлалт аргуудыг багтаасан “Зудыг давсан зузаан туршлага” номыг хэвлэж түгээв.

2015

Мерси Кор ХасБанкинд эзэмшдэг хувьцаагаа худалдаж, олсон орлогоороо “Даван туулах, дасах зохицох орон нутгийн иргэд” хөтөлбөрийг санхүүжүүлэв.

Мал сүрэгт тохиолдсон онцгой байдлын үед баримтлах заавар болон стандартуудыг (LEGS) Монголд нэвтрүүлээ

Авилгын эрсдэл, ил тод байдлын хэрэгцээг тайлбарласан “Орон нутгийн худалдан авах ажиллагааны сайн туршлагууд” ном хэвлэгдэн, улс даяар түгээгдлээ.

2017

ОБЕГ-тай Харилцан Ойлголцлолын Санамж Бичиг байгуулсаны үндсэн дээр цаг агаарын мэдээ хүргэх SMS системийг гамшгаас хамгаалах үндэсний тогтолцоонд нэвтрүүлэн ажиллахаар болов

2016

LEGS гарын авлага орчуулагдан, орон нутагт LEGS стандартыг танилцуулсан сургалтууд зохион байгуулагдлаа.

Цаг агаар, бэлчээрийн мэдээг гар утасны мессежээр дамжуулдаг систем (SMS систем) бий боллоо

Зудад нэрвэгдсэн хүмүүст хүмүүнлэгийн тусламж түгээлээ.

2019

SMS систем өвс тэжээлийн зах зээлийн үнэ ханшийг түгээж эхэллээ.

Малын эмч нарын Анхдугаар их хурал зохион байгуулагдав.

Монголд анх удаа гэрчилгээтэй PDS багш, хэрэгжүүлэгч бэлтгэгдлээ.

МКМ мал аж ахуйн бизнесүүдийг зардал хуваалцах зарчмаар дэмжих дэд тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжиж дуусав.

PDS аргачлалыг төрийн тандан судлах тогтолцоонд нэвтрүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлчээрийн менежментийг сайжруулахыг зорьсон LTS III хөтөлбөр хэрэгжиж эхэллээ.

2018

LTS II хөтөлбөрийн хүрээнд SMS систем Монголын бүх сум, багд цаг агаар, бэлчээрийн мэдээллийг хүргэж эхэллээ.

Мал амьтны өвчнийг оролцооны аргаар тандан судлах (PDS) аргачлалыг Монгол улсын мал эмнэлгийн практикт нэвтэрүүлээ.

ОБЕГ LEGS стандартын дагуу сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний шинэ загварыг боловсруулж, бүх суманд ашиглаж эхэллээ.

2021

МКМ төр, хувийн хэвшлийн түнш байгууллагуудад COVID-аас хамгаалах тусламж үзүүлэв.


ХААИС-тай хамтран залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малын эмч нарын бизнесийн ур чадварыг бэхжүүлэх онлайн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлээ.

Мерси Кор Монгол дахь үйл ажиллагаагаа зогсоолоо.



Монголын хөдөө орон нутгийн амьжиргааг дээшлүүлэх Мерси Корын аргачлал

Мерси Кор Монгол 22 жилийн турш төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, иргэдтэй хамтран **хөдөө орон нутгийн иргэдийн эмзэг байдлыг бууруулах, боломжуудыг нэмэгдүүлэхийг зорьж** ажилласаар ирсэн. МКМ нь түншлэл дээр суурилсан төсөл хөтөлбөрөөр дамжуулж зах зээлийн, засаглалын, нийгмийн тогтолцоог хөгжүүлэхийг дэмжиж, иргэдийн эдийн засаг, байгаль орчны хямрал хүндрэлийг даван туулах чадварыг бэхжүүлэх, соёл уламжлалаа хадгалахад нь анхаарлаа хандуулан ирсэн билээ.



МКМ-н хөгжлийн загвар


ХЭРЭВ малчид, хувийн хэвшил бизнесээ шинэчлэх, өргөжүүлэх, төрөлжүүлэх ур чадвартай, санхүүгийн эх үүсвэртэй, зах зээлийн мэдлэгтэй байсан бол

ХЭРЭВ иргэд, төрийн байгууллагууд гамшгийн эрсдэлийг бууруулах, малын эрүүл мэнд, бэлчээрийн менежментийг сайжруулах шинэлэг арга барил, бодлого нэвтрүүлсэн бол

ХЭРЭВ төр, орон нутгийн байгууллагууд иргэдтэй нээлттэй, хариуцлагатай, хүртээмжтэй ажиллах бодлого стратеги боловсруулсан бол

ТЭГВЭЛ хөдөөгийн иргэд эмзэг байдлаа бууруулж, боломжуудаа нэмэгдүүлэх бөгөөд иргэдийн хямрал хүндрэл давах чадвар бэхжиж, эдийн засгаа хөгжүүлэх боломж нь нэмэгдэнэ

ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖСЭН АЙМГУУД



ЭМЗЭГ БАЙДЛЫГ БУУРУУЛАХ, БОЛОМЖУУДЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЦОГЦ АРГАЧЛАЛ

Мерси Кор нь тулгарч буй хямрал хүндрэлүүдийг давах оновчтой бодлого арга барил боловсруулах ажлыг орон нутгийн түншүүдтэйгээ хамтран гүйцэтгэсэн. Энэ ажлын хүрээнд зах зээлийн тогтолцоог хөгжүүлэх (MSD) аргачлалыг нэвтрүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого боловсруулж, иргэний нийгмийг чадавхжуулах замаар эдийн засгаа хөгжүүлэх, байгалийн гамшгаас хамгаалах, нээлттэй, хариуцлагатай засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн билээ.

МКМ эдийн засгийг дэмжих, гамшгийн эрсдэлийг бууруулах, сайн засаглалыг бэхжүүлэх гэсэн гурван үндсэн чиглэлээр төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр хөтөлбөрүүд хоорондоо нягт уялдаа холбоотой байсан билээ.

Эдийн засгийн хөгжил. Мерси Кор нь бизнесийн ур чадварыг сайжруулах, зах зээлийн мэдээлэл түгээх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар Монголын хөдөө орон нутгийн эдийн засаг, ялангуяа мал аж ахуйн салбарт чухал ач холбогдолтой бизнесүүдэд хөгжих, төрөлжих, бэхжихэд нь дэмжлэг үзүүлсэн.

МКМ нь MSD аргачлалыг эрт нэвтрүүлсэн бөгөөд зах зээлийн холбоосыг бэхжүүлж, малчдын бүлэг, хоршоо байгуулснаар зах зээлийн хүртээмжийг дээшлүүлж, мал аж ахуйн бизнесүүдэд арилжаанд оролцох боломжийг нь нэмэгдүүлсэн билээ.

Гамшгийн эрсдэлийг бууруулах. Мерси Кор нь цаг агаар, өвс тэжээл, бэлчээр, гамшгаас урьдчилан сэргийлэх, тандан судалгаа, эпидемиологийн мэдээ мэдээлэл түгээх замаар мал маллагаа, малын эрүүл мэнд, нүүдэл суудалтай холбоотой шийдвэрүүдийг гаргахад иргэдэд дэмжлэг үзүүлсэн. Зах зээлийг хөгжүүлэх, гамшгийн эрсдэлийг

бууруулах арга барил ашиглан орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчдэд нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх чадавхаа хөгжүүлж, зудын хохирлыг давах, бэлчээрийн доройтлыг багасгаж, доройтлоос үүдсэн эдийн засгийн хүндрэлээс урьдчилан сэргийлэв. МКМ нь нийгэм, улс төр, эдийн засаг, экологийн хүндрэл хямралын хор уршгийг арилгаж, хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг хангахын тулд системийн түвшинд чадавх бэхжүүлэх ажил хэрэгжүүлсэн.

Сайн засаглал. Мерси Кор нь хөдөөгийн иргэдийн эдийн засаг, байгаль орчин, нийгмийн асуудалд нээлттэй, ил тод, хариуцлагатай хандах чадавхыг хөгжүүлэхийн тулд төрийн болон орон нутгийн байгууллагуудтай хамтран ажилласан. Тодруулбал, МКМ түншүүдтэйгээ хамтран хууль эрх зүйн, институцийн, захиргааны механизмыг байгуулах; орон нутгийн түвшинд төрийн төлөвлөлт, худалдан авалтын тогтолцоог сайжруулах; төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хооронд нээлттэй, ил тод, үр бүтээмжтэй харилцааг бэхжүүлэх; хөдөөгийн иргэний нийгмийг улам мэргэжлийн болгоход хувь нэмрээ оруулсан.

НИЙТЛЭГ СЭДВҮҮД

Хамтын ажиллагаа, оролцоо, хөдөөгийн иргэдийн асуудалд анхаарал тавих, иргэдийн чадавхыг бэхжүүлэх гэсэн зарчмуудыг МКМ 22 жилийн турш эрхэмлэж ирсэн. Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах замаар МКМ нь тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, сайн засаглал, байгаль орчны хариуцлагатай удирдлагыг дэмжсэн билээ.

Хөдөө орон нутагт гол анхаарлаа хандуулсан нь

МКМ нь хөдөөгийн иргэдийн оролцоо, хэрэгцээг хангах зорилгоор аймгуудад үйл ажиллагаагаа эхэлсэн. Сүүлийн жилүүдэд хот суурин газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн огцом нэмэгдэж байгаа нь хөдөөгийн зах зээл, эдийн засагт сөрөг нөлөө үзүүллээ. Зохих мэргэжил, ур чадваргүй шилжин суурьшигчдад хотод ажил эрхэлж амьдралаа залгуулахад хүндрэл учирдаг бөгөөд энэ шилжилт хөдөлгөөн нь улмаар мал аж ахуйн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлдэг. Төр болон хувийн хэвшил гол анхаарлаа хот суурин газар руу хандуулсан энэ цаг үед МКМ хөдөөгийн иргэдийн эмзэг байдлыг бууруулах, мал аж ахуйн салбарт суурилсан орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихийг зорьсон хэвээрээ байлаа. Гадны хямрал, хүндрэлийг даван туулах чадвартай, соёл уламжлалаа хадгалсан нийгэм байгуулах үндсэн арга нь зах зээлийг хөгжүүлэх, байгаль орчны тогтвортой менежментийг нэвтрүүлэхэд оршдог.

Түншлэл байгуулсан нь

МКМ нь төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, иргэд зэрэг олон төрлийн түншүүдтэй хамтран ажиллаж ирсэн. Түншлэл байгуулсаны үр дүнд МКМ-ын төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд Монгол иргэдийн оролцоо шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд Монголчууд идэвхтэй оролцсон явдал нь хөтөлбөрийн үр дүнг цаашид системжүүлэх, тогтвортой өөрчлөлт бий болгоход нөлөөлсөн.

Хямрал бэрхшээлийг даван туулах хөтөлбөрүүд

Иргэд, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах нь хямрал бэрхшээлийг даван туулах; учирч болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх; эдийн засаг, нийгэм, байгаль орчны эмзэг байдлыг үүсгэдэг асуудлуудыг шийдвэрлэх чадвартай гэж МКМ үздэг.

Хөгжлийн салбарт “Даван туулах, дасан зохицох чадвар” гэдэг нь харьцангуй шинэ ойлголт боловч Мерси Кор нь уг чадварыг бэхжүүлэх ажлыг хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд тогтмол гүйцэтгэж ирсэн.



“МКМ үргэлж хөдөөгийн иргэд, засаг захиргаа, бүлэг хоршоотой ажиллаж ирсэн. Монголын хөдөө орон нутагт Мерси Корыг маш сайн мэднэ. Аймгуудад төлөөлөгчийн газар байгуулснаар МКМ орон нутгийн захиргаа, малчдын бүлэг, ТББ, иргэдийн чадавхыг бэхжүүлэхэд тусалсан юм.”

Г.Пагма, “Хөдөөгийн бизнес эрхлэгчдэд олгох зах зээлийн боломжууд” төслийн менежер, 2009-2012



“МКМ бол үргэлж Монгол улсын найдвартай түнш байсан. Төрийн байгууллагуудтай түншлэх нь амжилтанд хүрэх гол хүчин зүйл. МКМ түншээ зөв сонгож, чадавхыг нь сайжруулан, төслийг хамтран хэрэгжүүлсэн. Түншийн тоонд ОБЕГ/ аймгуудын ОБГ, Мал эмнэлгийн газар, Хөдөө аж ахуйн газар зэрэг орсон.”

МЭЭГ-ын Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга Т.Тунгалаг



Фото зураг: Шон Шеридан (2017)

“Даван туулах дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” (RCP) хөтөлбөр

Мерси Корын Глобал Сангаас санхүүжүүлсэн RCP хөтөлбөр нь иргэдийн даван туулах чадварыг бэхжүүлэх аргыг өргөн нэвтрүүлсэн шилдэг хөтөлбөр болохыг зорьсон. RCP нь орон нутагт гамшгийн эрсдэл, бэлчээрийн доройтол, эдийн засаг экологийн хямралаас малчид, иргэд, бизнес эрхлэгчдийг урьдчилан сэргийлэхэд MSD аргачлалыг ашигласан. Мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээний оролцогчдын чадавхыг үнэлж тогтоосноор RCP хөтөлбөр нь тэдний амьдарч буй эдийн засаг, нийгэм, байгаль орчны харилцан уялдаатай тогтолцоог бэхжүүлсэн. Олон талт оролцоон дээр тулгуурлан RCP хөтөлбөр нь нийгмийн зан үйл, холбоос, тулгарч буй саад бэрхшээлийг шийдэх замаар хямрал хүндрэлийг даван туулах чадварыг хөгжүүлсэн. RCP нь даван туулах, дасан зохицох чадварыг бэхжүүлэх аргачлалыг боловсруулан ашиглахад хөгжлийн бусад байгууллагуудад үлгэр жишээ болж ажилласан билээ.

Хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлэхэд хэн оролцдог вэ?


Олон мянган жилийн турш нүүдэлчид Монголын өргөн уудам тал нутагт тэмээ, адуу, үхэр, хонь, ямаа зэрэг таван хошуу малаа маллаж, нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн билээ. Монголд нүүдлийн мал аж ахуй эрхлэх нь амьжиргааны гол эх үүсвэр, нийгмийн баталгаа, үндэсний уламжлалт ёс заншил юм.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед бүх бүтээгдэхүүнээ улсад тушаадаг байсан малчдад чөлөөт зах зээлд шилжсэнээр өөрсдөө бизнесээ удирдах шаардлага тулгарсан. Малчдад чөлөөт зах зээлд бүтээгдэхүүний үнэ ханшийг тогтоох, хамтран худалдан авах, хоршиж ажиллах гээд олон төрлийн мэдлэг, ур чадвар хэрэгцээтэй байсан. Бид хөдөөгийн амьжиргааг дээшлүүлэх хүрээнд нэмүү өртгийн сүлжээний оролцогчидтой хамтран ажилласан. Үүнд:

- › Малыг өсгөж, нийлүүлдэг малчид
- › Мал таргалуулж борддог аж ахуй
- › Малын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг малын эмч
- › Чанартай, ашиг шим өндөртэй малыг үржүүлэх алба
- › Малын тэжээл тариалдаг тариаланчид, фермерүүд
- › Мал нядлах, мах боловсруулах үйлдвэрүүд
- › Хөдөө орон нутагт зээл, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг банкууд
- › Цаг агаар, бэлчээрийн нөхцөл байдал, малын өвчин, үнэ ханшийн мэдээлэл түгээдэг мэргэжилтнүүд
- › Улс төр, хууль зүйн орчныг бүрдүүлдэг орон нутгийн болон үндэсний засаг захиргаа



Фото зураг: Шон Шеридан (2017)



Мерси Кор анх байгуулагдах үеэсээ “Монголын хөдөө орон нутагт тогтвортой өсөлтийг хангах чадвартай эдийн засаг, эрүүл иргэний нийгмийг байгуулах” зорилго тавьж байсан. Манай хөтөлбөр бүр өмнөх туршлага, амжилт, сургаж дээр тулгуурлаж, хөдөө орон нутагт тогтвортой амьжиргааг бий болгоход чиглэж байсан. МКМ нь малчид, иргэний нийгмийн дуу хоолойг сонсох, Монголын хөгжилд хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг ролийг илүү онцлохыг тэмүүлж байсан.

ХАБДХ буюу “Хөдөөгийн агробизнесийг дэмжих хөтөлбөр”

Говийн Санаачилга төслүүдийн амжилтыг бусад аймгуудад нэвтрүүлсэн; малын чанар ашиг шим, нэмүү өртгийн сүлжээ, зах зээлийн хүртээмж, хүнсний аюулгүй байдал, малын эрүүл мэнд, зээлийн баталгаа, малчдын бүлэг, бизнесийг хөгжүүлэх үйлчилгээний чадавхийг бэхжүүлэхэд анхаарлаа хандуулж, хөдөө аж ахуйн бизнесүүдийг дэмжсэн.

RCP хөтөлбөр MSD арга ашиглан мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх, зах зээлийн мэдээлэл, хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх боломжийг бий болгох замаар хөдөөгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлсэн.

2000

2005

2010

2015

2020

“Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачилга I” төсөл санхүү, бизнесийг хөгжүүлэх үйлчилгээг сайжруулах, мал аж ахуйн менежмент, бэлчээр, усны менежментийг хөгжүүлэх, бизнесийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан.

“Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачилга II” төсөл Говийн Санаачилга I төсөл дээр үндэслэн хөдөө аж ахуй, бизнес, мэргэжлийн сургалтыг малчдын бүлэг, хоршоодод хүргэх, үйлдвэрлэгчид болон ханган нийлүүлэгчдийг хооронд нь холбох, бизнесүүдэд зээлийн баталгаа олгох, орон нутгийн сургалт, техникийн туслалцаа үзүүлэх үйлчилгээ эрхлэгчдийн чадавхийг бэхжүүлэх, бизнесийн мэдээллийг түгээж, хөдөөгийн бизнесүүдийг бэхжүүлэхийг зорьсон.

“Хөдөөгийн бизнес эрхлэгчдэд олгох зах зээлийн боломжууд” төсөл зах зээлийг хөгжүүлэх, бизнесийг дэмжих үйлчилгээг бэхжүүлэх, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, төрийн өрсөлдөөнт, ил тод худалдан авалтыг хөхүүлэн дэмжих замаар Монголын малчид, мал аж ахуйн бизнес эрхлэгчдийн орлого нэмэгдэв.



МЕРСИ КОРЫН ОЛОЛТ, АМЖИЛТ

22 жилийн хугацаанд МКМ-ын хөтөлбөрүүд Монголын бүх 21 аймгийн малчид, бизнесүүдийг бизнесийн ур чадвар эзэмших, зах зээлийн хэлхээ холбоос байгуулах, байгалийн гамшгаас хамгаалах чадварыг бэхжүүлэх, ил тод, нээлттэй засаглалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ирсэн билээ. Доорх тайланд МКМ-ын гурван үндсэн чиглэлийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг тайлбарласан:

- › Хөдөөгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилготой **эдийн засгийн хөгжил**
- › Төр иргэд хоорондын уялдаа холбоог сайжруулж, малын эрүүл мэнд, бэлчээрийн менежментийг сайжруулж, гамшгийн төлөвлөгөө, бодлого боловсруулах замаар **гамшгийн эрсдэлийг бууруулах.**
- › Ил тод, мэдрэмжтэй, иргэдэд хүртээмжтэй үйл ажиллагаа, бодлогыг хэрэгжүүлснээр иргэний нийгэм, төрийн байгууллагуудыг бэхжүүлэх **сайн засаглал**

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Мерси Кор Монгол нь хөдөөгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлсэн

1990-ээд онд Монгол улс ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжихэд улсын өмч хувьчлагдаж, малчид малаа дахин өмчлөх, хувийн бизнесээ нээх боломжтой болсон юм. Эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгохын тулд хөдөө орон нутгийн иргэд бизнес эрхлэх ур чадвар эзэмших, санхүүжилт босгох, таатай эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай байдаг. МАА-н нэмүү өртгийн сүлжээний чухал хэсэг болох малчид, жижиг бизнес эрхлэгчид шинэ эдийн засгийн тогтолцоонд бизнесийн ур чадвараа сайжруулах, санхүүжилт авах, зах зээлийн мэдээ, мэдлэгтэй болох хэрэгцээ тулгарсан. Хөдөө орон нутгийг үйлдвэр зах зах зээлтэй холбох дэд бүтэц хэрэгтэй. Зах зээлийн оролцогчдыг шийдвэр гаргагчидтай холбохын тулд иргэний нийгэм, хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагаа сайжрах ёстой.

МКМ нь орон нутагт бизнес эрхлэхийг дэмжиж, хөрөнгө оруулж, нэмүү өртгийн сүлжээний оролцогчидтой хамтран ажиллаж, хөдөөгийн иргэдийн тогтвортой амьжиргааг бий болгосон. Эхлээд говийн бүсд, дараа нь улс даяар МКМ нь бизнесийн ур чадвар эзэмшүүлэх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зах зээлийн үйл ажиллагааг дэмжих замаар орон нутгийн зах зээлийг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлсэн.



Эко Хан Буян хоршооны гишүүн Энх-Эрдэнэ 2017 онд RCP хөтөлбөртэй малын тэжээл үйлдвэрлэх чиглэлээр хамтран ажилласан юм. “Бидэнд олон бэрхшээл тулгардаг. RCP хөтөлбөр чанартай үр авахад тусалж, бид малын тэжээлийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлсэн” хэмээн ярилаа. Тэжээл нь өвөлжилт хүндэрсэн үед малын эрүүл мэндийг хамгаалж, малын ашиг шимийг сайжруулахад тусалсан

Фото зураг: Шон Шеридан (2017)

Фото зураг: Шон Шеридан (2017)

Үр нөлөө: ХӨДӨӨГИЙН БИЗНЕСҮҮД ЗАХ ЗЭЭЛИЙН ХОЛБООСОО БЭХЖҮҮЛСНЭЭР НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭТЭЙ ИЛҮҮ САЙН ХОЛБОГДСОН

Мерси Кор нь малчдын хоршоо бүлэг байгуулж, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлсэн

Чөлөөт зах зээлд ажиллахад амаргүй байдаг. Малчид үйлдвэрлэлийн орц худалдан авах, малын түүхий эдийг борлуулахад хүндрэлтэй тулгарснаар үйлдвэрлэлийн зардал ихэсч, чанар муудаж, орлого буурч, санхүүгийн хямрал, байгалийн гамшгийг давах чадварт сөргөөр нөлөөлсөн. МКМ нь малчид, жижиг бизнесүүдийн зах зээл, бүтээгдэхүүний төрөл, эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх, бизнесийн мэдээлэл түгээхэд дэмжлэг үзүүлэхийн тулд бизнесийн холбоод, ханган нийлүүлэгчид, боловсруулагчид, үйлдвэрлэгчидтэй хамтран ажиллалаа.

Малчид хоршоо, үйлдвэрлэгчдийн өргөтгөсөн бүлэг (ҮӨБ) зэрэг албан ёсны аж ахуйн нэгж байгуулах явцад МКМ малчдыг бизнесийн сургалтанд хамруулж, бусад туслалцаа дэмжлэг үзүүлэв. Эхэндээ малчид зохион байгуулалтад орохоос болгоомжилж байсан боловч чадавх бэхжүүлэх арга хэмжээ, зах зээлийн мэдээ, зах зээлийн холбоос, зээл авах боломж зэрэг ажлууд хоршоо байгуулах сонирхлыг нэмэгдүүлсэн. Төрийн дэмжлэг, бизнесийн таатай орчин нь хоршоо, ҮӨБ байгуулахад эерэг нөлөө үзүүлсэн.

Говийн Санаачилга I төслийн хүрээнд говийн 6 аймагт 10 мянган гишүүнтэй 250 малчны бүлэг байгуулахад тусалж, хөдөөгийн бизнесүүдэд тохирсон бизнес төлөвлөгөөний загварыг боловсруулсан.

Говийн Санаачилга II төслийн хүрээнд 839 малчны бүлэг, хоршоо, 305 малчны бус бизнесүүд бизнес төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэний үр дүнд 2004-2008 оны хооронд 11.2 сая долларын борлуулалт хийсэн. Энэ хугацаанд малчдын бүлгүүд МКМ-ын бизнес төлөвлөгөөний сургалтанд хамрагдаж, техникийн туслалцаа авсан аж.

“Зах зээлийн боломжууд” төслийн хүрээнд МКМ нь малчид хоршоотой хамтран 28 ҮӨБ байгуулсан нь зах зээлээ өргөжүүлэх, бүтээгдэхүүний чанараа дээшлүүлэх, худалдааны хэлэлцээр хийх чадвар эзэмших, бизнесийн томоохон гэрээ байгуулах боломжийг олгов.

Малчдын бүлэг, хоршоо, ҮӨБ байгуулагдах нь хөдөө аж ахуйн зах зээлийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны ач холбогдлыг ойлгох, орон нутагт орох татварын хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсан.

Энэ хугацаанд бүртгүүлсэн хоршоодын тоо 16 дахин нэмэгдсэн байна. 2011 онд батлагдсан хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиар

Төрийн бодлоготой эдийн засгийн хөгжлийн ажлаа нийцүүлсэн нь

Мерси Кор нь 1999 онд бизнесийн экосистемийг дэмжих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, төр болон бизнесийн удирдагчдын чадавхыг сайжруулах зорилгоор Монголчуудтай хамтран эдийн засгийн хөгжилд нэн шаардлагатай орчин буюу тогтолцоо, сүлжээ, институциудыг байгуулж эхэлсэн юм. МКМ нь хөтөлбөрүүдээ засгийн газрын бодлого, стратегитэй нягт уялдуулж, хөтөлбөрийн үйл ажиллагаа, үр дүнг Монголын нөхцөл байдалтай нийцүүлэх, төрөөс зохистой бодлого, үйл явц, журмыг боловсруулахад тусалсан. МКМ-ын хэрэгжүүлсэн олон арга хэмжээ нь төрийн бодлогыг дэмжиж байсан. Үүнд 2003 онд зарласан “Хоршоог дэмжих жил”-ийн хүрээнд засгийн газартай хамтран ажиллах, сүүний үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан хувьсгал” хөтөлбөрийг дэмжих, ЖДҮ-г төрийн бодлого, стандартад нийцүүлэн ажиллахад тусламж үзүүлэх гээд олон арга хэмжээ орно.

хөдөө аж ахуйн хоршоод биржийн арилжаанд орох эрхтэй болсон. Үүнээс гадна Засгийн газар түүхий эдийн (ялангуяа ноос, арьс шир) борлуулалтад үнийн урамшуулал олгож эхэлсэн. Эдгээр өөрчлөлтүүд хоршооны хөгжлийн шинэ үе шат эхэлсэний дохио байлаа. Хоршоодын амжилт нь бизнес эрхлэгчдэд сургалт, зөвлөгөө өгдөг орон нутгийн бизнесийг дэмжих байгууллага, ТББ хөгжих нөхцлийг бүрдүүлсэн билээ.



Фото зураг: Тэтчер Күк (2008)

Өмнөговь аймгийн Баянзаг сумын цагаан идээ үйлдвэрлэдэг бүлгийн малчин

“МКМ нь орон нутгийн иргэд, ялангуяа малчдын бүлэг, хоршоотой ажилладаг бөгөөд нэмүү өртгийн сүлжээ, иргэдийн оролцоог дээшлүүлэх, бизнес иргэдийг хооронд нь холбох, түншлэл байгуулах гээд олон өвөрмөц арга барил ашигладаг.”

-Өмнөговь аймгийн зохицуулагч Ө.Эрдэнэбилэг

Мерси Кор нь малчдын бүлгүүдийн бизнес төлөвлөлтийг дэмжсэн

Малчид хоршоо, нөхөрлөл, ХХК зэрэг бүртгэлтэй аж ахуйн нэгж байгуулах явцад МКМ нь бизнес төлөвлөлт, менежмент, үйл ажиллагааг сайжруулах зэрэг арга хэмжээ зохиож дэмжиж байсан.

Говийн Санаачилга, “Зах зээлийн боломжууд”, ХАБДХ төслүүдийн үр дүнд малчид өөрсдийгөө “гэр бүлээ тэжээх ажил” гэхээсээ илүү “бизнес” гэж үзэх болсон байна.

Мерси Кор Зах зээлийн өдөрлөг зохион байгуулж, орон нутгийн үйлдвэрлэгчдэд бүтээгдэхүүнээ борлуулах боломж олголоо

2000-аад онд бизнесүүдэд олон асуудал тулгардаг байлаа: зах зээлээс алслагдмал байдал, зах зээлийн үнэ ханшийн мэдээлэл хомс, үйлдвэрлэлийн зардал өндөр, ашиг нь бага. Энэ асуудлыг шийдэхийн тулд МКМ үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, иргэд бизнесүүдийг хооронд нь холбож, ноолуур, сүү цагаан идээ, мах, ноос, модон эдлэл, гар урлал, барилгын материалыг худалдах болон худалдан авах, зах зээлээ өргөжүүлэх, мэдээлэл солилцох, худалдааны гэрээ байгуулах нөхцлийг бүрдүүлсэн билээ.

2000-2015 онд Мерси Кор нийт 325 зах зээлийн өдөрлөг, үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, эдгээр арга хэмжээнд нийт 1.6 сая хүн, 25 мянган бизнес оролцож, 14.4 сая ам долларын борлуулалт хийсэн ажээ.

2000-2015 онд МКМ үзэсгэлэн худалдааг зохион байгуулдаг байсан бол сүүлд нь аймгийн удирдлага, орон нутгийн бизнесүүд, ТББ-ууд аажмаар зардал, зохион байгуулалтыг бүрэн хариуцдаг болсон.

Үр нөлөө: хөдөөгийн малчид, бизнес эрхлэгчид бизнесээ хөгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн үр чадвараа дээшлүүлсэн

Мерси Кор нь бизнесийг дэмжих үйлчилгээ (БДҮ) эрхлэгчдэд зориулж тогтвортой бизнес загварыг бий болгосон

МКМ нь хөдөө орон нутгийн бизнес эрхлэгчдэд бизнесээ хөгжүүлж, зах зээлээ өргөжүүлэхийг зорьж мэргэжлийн зөвлөхүүдийн сүлжээг байгуулсан. МКМ нь орон нутгийн зөвлөхүүдийг БДҮ эрхлэх сургалтанд хамруулж, БДҮ эрхлэгчдийн сүлжээ байгуулж, бизнес, малчдад үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлсэн юм.

Говийн Санаачилга | төслийн хүрээнд МКМ нь орон нутгийн бизнесүүдэд эрэлт хэрэгцээг тодорхойлох, бүтээгдэхүүнийхээ төрлийг олшруулах, маркетинг санхүүжилтийн төлөвлөгөөг боловсруулах, мөн засаг

захиргаатай хамтран чанарын стандартыг хэрхэн хангах чиглэлээр ажиллахад нь туслах зорилгоор хараат бус БДҮ эрхлэгчдийн сүлжээг үүсгэж эхлэв.

2010 онд МКМ нь БДҮ эрхлэгчдийг хооронд нь болон үйлчлүүлэгчидтэй холбох, нөөц боломжоо хамтран ашиглах, бизнесийн шинэ мэдээлэл олж авах, бизнесийн холбоос тогтоох, БДҮ үзүүлэх стандарт тогтоох зорилгоор ИнфоКон компанитай хамтран Zuvluh.mn сайтыг боловсруулахад тусалсан.

2012 онд “Зах зээлийн боломжууд” төсөл болон ХАБДХ дуусахад БДҮ эрхлэгчид зөвлөхүүдийг сургаж, МКМ-ээс бүрэн хараат бус үйл ажиллагаа явуулж, төлбөртэй үйлчилгээ үзүүлж байв.

Мерси Кор орон нутгийн бизнес, малчдын бизнесийн мэдээллийн хүртээмжийг сайжруулсан

Малчид бизнес эрхэлж, бизнесийн үр чадвар эзэмшиж эхлэхтэй зэрэгцэн Говийн Санаачилга төсөл нь Хөдөөгийн Бизнес Мэдээ (ХБМ) сонин, радио, телевиз байгуулж үндэсний болон орон нутгийн бизнес, цаг агаарын мэдээ түгээж эхэллээ.

1999-2012 оны хооронд 130 гаруй мянган бизнес эрхлэгчид 12 гаруй мянган сургалт, зөвлөгөөнд хамрагдаж, 3400 бизнес эрхлэгчид бизнес төлөвлөгөө боловсруулж зээл авсан.

Говийн Санаачилга болон ХАБДХ-ийн хүрээнд БДҮ сургалтанд хамрагдсан бизнес эрхлэгчид сургалт, техникийн туслалцааны ачаар орлого нь 10-15% өссөн гэж мэдэгдэв.

ХБМ-ийн “Ирээдүйгээс ирсэн малчин” радио жүжиг зорилтот аймгуудад иргэдийн нийт 75%-д хүрч, хөдөөгийн бизнес эрхлэгчдэд анх удаа хэрэгцээтэй мэдээлэл өгч тусалжээ. ХБМ-ийн өөр нэг шинэлэг, эрэлт ихтэй бүтээгдэхүүн бол “Зах зээл ажиглагч” байсан. “Зах зээл ажиглагч” нь зах зээлийн үнэ ханшийг мэдээлж, хот хөдөөгийн үнийн ялгаа зөрүүг арилган хамгийн өндөр үнээр бүтээгдэхүүнээ борлуулах боломж олгосон.

“Зах зээл ажиглагч” нь үүрэн телефоны Мобиком компанитай хамтарч бүх аймгийн төв, Улаанбаатарын түүхий эдийн үнийн мэдээллийг өдөр тутам мессэжээр илгээх шинэ үйлчилгээ эхлүүлсэн.

2000 онд анх нээгдэж, 2008 онд ажиллагаагаа бүрэн автоматжуулсан “Зах зээл ажиглагч” нь хот хөдөөгийн үнийн ялгаа зөрүүг арилгаж, алслагдсан малчид, бизнесүүдэд өдөр тутмын зах зээлийн үнэ ханшийг мэдээлж байсан. Зах зээлийн ажиглагчид өдөр тутмын 44, улирлын чанартай 7 түүхий эдийн зах зээлийн үнийг мессежээр түгээж байв.

- 2009 онд Говийн Санаачилга II төсөл хаагдахад “Бизнесийн хэвлэл мэдээлэл” ТББ радио нэвтрүүлэг, сэтгүүл, вэбсайт, “Зах зээлийн ажиглагч” үйлчилгээг хариуцах болсон.
- “Зах зээлийн боломжууд” төслийн хүрээнд “Зах зээлийн ажиглагч”-ийг 2012 онд БДҮ эрхлэгчдийн Zuvluh.mn сүлжээтэй холбосон. Уг сүлжээтэй холбогдсноор мах, ноос, ноолуур, гурил, будааны орон нутгийн үнэ ханшийг долоо хоног бүр цуглуулж, БДҮ эрхлэгчдэд түгээдэг байсан.
- 2019 онд МКМ болон Дэлхийн хүнсний хөтөлбөр нь Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), Үндэсний статистикийн хороотой (ҮСХ) -той хамтарч мэдээлэл цуглуулах, дамжуулах бүх механизмуудыг ашиглан (жишээ нь LTS II төслийн хүрээнд МКМ, ОБЕГ-ын хамтран байгуулсан цаг агаарын мэдээ дамжуулдаг SMS систем) 30 зорилтот сум, 21 аймгийн төвийн өвсний үнэ ханшийг гар утасны хэрэглэгчдэд түгээдэг боллоо.

Үр нөлөө: ОРОН НУТАГТ САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ САЙЖИРЧ, БИЗНЕС ЭХЛҮҮЛЭХ, ӨРГӨЖҮҮЛЭХ, ТӨРӨЛЖҮҮЛЭХ БОЛОМЖ НЭМЭГДСЭН

Мерси Кор “Зээлийн баталгаа гаргах хөтөлбөр” (ЗБГХ)-өөр дамжуулан хөдөөгийн бизнесүүдэд санхүүжилт авах боломжийг нь нээж өгсөн

Бизнесээ өргөжүүлэх, төрөлжүүлэх нь хөрөнгө оруулалт шаардагддаг боловч ихэнх ЖДҮ-д зээлийн барьцаа хангалтгүй, зээл авч цаг тухайд нь төлсөн гэх түүх байдаггүйн улмаас зээл авч чаддаггүй. 2004 онд ХАБДХ-ийн хүрээнд, МКМ арилжааны банкуудтай хамтран бизнесээ хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт авахад нь туслах зорилгоор ЗБГХ эхлүүлсэн. ЗБГХ-ийн хүрээнд МКМ бизнесүүдэд зээлийн баталгаа гаргаж, зээлийн хүүг бууруулсан билээ. Түүнчлэн ЖДҮ-д бизнес төлөвлөгөө боловсруулах, зээлээ оновчтой ашиглахыг суралцсан бөгөөд цаашид зээл авахад шаардлагатай санхүүгийн мэдлэгтэй болсон юм. Хөдөөгийн бизнесүүдийг дэмжих ажил анх 2000 онд Говийн Санаачилга I төслийн хүрээнд эхлэж, цаашид ХАБДХ, “Зах зээлийн боломжууд” төслийн хүрээнд 2012 он хүртэл үргэлжилсэн бөгөөд ЗБГХ нь энэ ажлын гол хэсэг байлаа.

ЗБГХ-ийн үйлчлүүлэгчдэд бизнес төлөвлөгөө боловсруулах, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтийг хянахад төлбөртэй үйлчилгээ үзүүлэх гэрээг МКМ БДҮ эрхлэгчидтэй байгуулсан. БДҮ эрхлэгчидтэй хамтран нийт 627 зээл олгосон. Гол зорилт нь ЗБГХ-ийг өргөжүүлж, хөдөө орон нутагт бизнесийг тогтвортой хөгжүүлэх суурийг байгуулахад оршиж байсан юм.



Фото зураг: Тэтчер Күк (2001)

Бизнес эрхлэгч зээлээр талх нарийн боовны бизнесээ өргөжүүлээ

Пүрэвдорж эхнэрийн хамтаар Өвөрхангай аймагт дөрвөн ажилтантай талх нарийн боовны жижиг цех ажиллуулдаг байсан. 2009 онд Пүрэвдорж нь бизнесээ өргөжүүлэх зорилгоор 5 сая төгрөгийн зээл авч, ЗБГХ-өөс зээлийн 50%-ийн баталгаа гаргасан юм. Бизнесийн эзэд МКМ-ын чадавх бэхжүүлэх сургалтанд идэвхтэй хамрагдсан. Тухайлбал ХАБДХ-өөс зохион байгуулсан бялууны сургалт, МКМ-ын түнш Хөгжлийн Шийдэл ТББ-аас зохион байгуулсан бизнесийн сургалтад оролцсон. 2011 онд эдний компани 20 сая төгрөгийн зээлийг ЗБГХ-ийн хүрээнд нэмж авч үйлдвэрийн байраа барьж, тоног төхөөрөмжөө шинэчилсэн байна. Үр дүнд нь ажилтнуудын тоо 15 хүрч, 10 гаруй нэр төрлийн нарийн боовны бүтээгдэхүүн, 7-8 төрлийн түргэн хоолны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, кафе ажиллуулдаг болсон. Пүрэвдоржийн бизнес аймагтаа түргэн хоолны хоёр дахь том бизнес болж хувирсан.



Фото зураг: Шон Шеридан (2017)

› RCP хөтөлбөр, Элит хүнс ХХК

Мал аж ахуйн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг өргөжүүлсэн нь

Элит Хүнс ХХК нь малын зогсоол, хүзүүвч, зөөврийн хашаа зэрэг мал аж ахуйн төхөөрөмж үйлдвэрлэдэг залуу даргатай залуучуудын бизнес байлаа. RCP хөтөлбөртэй хамтран бизнесээ өргөжүүлэх, төхөөрөмжийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, улмаар малын эрүүл мэнд, үржлийн үйлчилгээ үзүүлэхэд хувь нэмрээ оруулах төсөл хэрэгжүүлсэн.

Төслийн хүрээнд Элит хүнс ХХК 150м² талбай бүхий орчин үеийн гагнуурын төхөөрөмжөөр тоноглогдсон үйлдвэрийн байрыг ашиглалтад оруулан тоног төхөөрөмжийн чанар, үйлдвэрлэлийн үр ашгаа сайжруулсан юм. Үйлдвэрлэлийн хүчин чадал нь гурав дахин нэмэгдэж, борлуулалтын орлого нь өмнөх жилтэй харьцуулахад зургаа дахин өссөн.

› Мерси Кор хөдөө орон нутгийн банкны үйл ажиллагааг өргөжүүлсэн тухай

2000 оны үед Мерси Кор нь Монголд санхүүгийн үйлчилгээнд шинэлэг зүйлүүдийг зоригтой нэвтрүүлж байлаа. ТББ-ууд банкны үйлчилгээ эрхэлдэггүй хэдий ч, Мерси Кор нь орон нутагт боломжийн хүүтэй зээлийн эрэлт хэрэгцээ өндөр байгааг олж харсан. Говийн Санаачилга I төслийн хүрээнд Мерси Кор нь Говийн Эхлэл хэмээх банк бус санхүүгийн байгууллагыг орон нутгийн жижиг бизнесүүдэд хүртээмжтэй зээл олгох зорилгоор байгуулсан. Хоёр жилийн дотор энэхүү байгууллага нь говийн таван аймагт нийт 1 сая гаруй ам. долларын 300 гаруй зээлийг олгож, эргэн төлөлт нь бараг 100% хүрсэн билээ. Энэ нь бизнес эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээ авах хэрэгцээ өндөр байгааг харуулсан.

Санхүүгийн салбарын хүрээг өргөжүүлэхийн тулд Говийн Эхлэл ББСБ нь НҮБ-ын Хөгжлийн Алтан Сан байгууллагатай нэгдэн өсөн нэмэгдэж буй хөдөө орон нутгийн болон хот суурин газрын иргэдэд үйлчлэхийг зорьсон ХасБанкийг байгуулсан юм. Энэ шинэ банк нь улс даяар үйл ажиллагаа явуулж, ЖДҮ-ийн хэрэгцээнд нийцсэн банкны үйлчилгээг үзүүлэх болсон. ХасБанк улмаар хөдөө орон нутгийн иргэдэд үйлчлэх эрхэм зорилготой Монголын шилдэг арилжааны банк болж хөгжсөн билээ.

Мерси Кор ХасБанкинд олон жил зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаад 2015 онд хувьцаагаа худалдсанаар банкны үйл ажиллагаанд албан ёсоор оролцохоо

больсон. Хувьцааныхаа орлогоо RCP хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулж, Монгол улсын хөгжилд дахин хөрөнгө оруулав.

ХасБанк өнөөгийн байдлаар 21 аймгийн 76 салбар нэгжээр дамжуулан нэг сая гаруй харилцагчтай, Монгол улсын хамгийн том бичил санхүүгийн байгууллага, хоёр дахь том банк болж чадсан. Хөгжлийн хөтөлбөрөөс нийгэмд үйлчилгээ үзүүлдэг банк болтол хөгжсөн ХасБанк нь бичил санхүүгийн салбарт үлгэр жишээ болсон билээ.*


* <https://www.xacbank.mn/page/about>

ОН ЦАГИЙН ДАРААЛал: МЕРСИ КОР, ХАСБАНК ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



"ХасБанк нь Азийн бичил санхүүгийн салбарт хамгийн амжилттай хэрэгжсэн төсөл болсон гэж би хувьдаа боддог. Учир нь тэд 0 доллараас 1 тэрбум ам долларын хөрөнгөтэй болтол хөгжиж чадсан юм"

Стив Митчел, Мерси Корын Санхүүгийн захирал, санхүүгийн дэд ерөнхийлөгч асан (2002-2021), ХасБанкны ТУЗ-ын гишүүн (2003-2015).



Монгол орон эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай бөгөөд сүүлийн жилүүдэд бэлчээрийн доройтол, цаг уурын өөрчлөлт зэрэг гамшигтай тулгарч байгаа билээ. Зудын улмаас мал сүргийн тоо толгой хорогдож, малчдын амжиргаанд сөргөөр нөлөөлдгөөс хамааран МКМ байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, эрсдлийг бууруулах чадавхийг бэхжүүлэх зорилготой хөтөлбөрүүдийг орон нутгийн иргэд, төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх болсон юм.

Говийн бэлчээр төсөл Малчид болон төрийн албан хаагчдад малын тэжээл, тэжээллэгийн нөхцөл байдал, бэлчээрийн цаашдын төлөв байдлын талаар мэдээлэл хүргэх дэд бүтцийг хөгжүүлэн, мал аж ахуйн эрсдлийг урьдчилан мэдээлэх системийг бий болгов.

Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь (LTS) төсөл Урьдчилсан мэдээлэх системийг байгуулж, зудыг давах тэргүүн туршлага, сургамжийг дэлгэрүүлснээр малчид, орон нутгийн эдийн засагт үзүүлэх зудын хохирлыг бууруулахад анхаарч ажиллав.

“Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь-3” (LTS III) төсөл Бүх түвшний түншүүдтэй хамтран гамшгийн эрсдэлийг бууруулах, хил дамжин халдварладаг малын гоц халдварт өвчний тандан судлах, бэлчээрийн менежментийг сайжруулах аргачлалуудыг төрийн тогтолцоонд нэвтрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд гүйцэтгэв.

2000

2005

2010

2015

2020

Мал аж ахуйн эрсдлийг урьдчилан мэдээлэх тогтолцоо (МАЗЭУМТ) төсөл Нийт 21 аймагас мэдээлэл цуглуулан, дүн шинжилгээ хийснээр бэлчээрийн нөхцөл байдлыг харуулсан 12 төрлийн багц зураг боловсруулан түгээж, энэ чиглэлийн эрдэмтэн судлаачдыг бэлчээрийн ургац тооцоолох PHYGROW арга ашиглаж сургалаа.

“Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь-2” (LTS II) төсөл Цаг агаар, бэлчээрийн мэдээг хүргэх гар утасны мессеж (SMS) системийг байгуулсан; гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чадавхийг аймаг сумын түвшинд сайжруулсан; мал амьтны өвчнийг оролцооны аргаар тандан судлах (PDS) аргачлалыг нэвтрүүлж, малын халдварт өвчний тархалтыг хянахад дэмжлэг үзүүлсэн; мал сүрэгт тохиолдсон онцгой байдлын үед баримтлах заавар болон стандартуудыг (LEGS) орон нутгийн иргэдэд танилцуулж, мэдлэг олгосон.



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ

Мерси Кор төр иргэд хоорондын уялдаа холбоог бэхжүүлж, малын эрүүл мэнд болон бэлчээрийн менежментийг тусгасан гамшгаас хамгаалах бодлого, төлөвлөлтийг сайжруулсан.

Хэдийгээр мал аж ахуйн бизнест үзүүлсэн дэмжлэг эдийн засгийн өсөлтийг бий болгосон боловч МАА-н салбар нь байгаль орчноос үлэмж хамааралтай, бүх ололт амжилтаа нэг шөнийн дотор алдах эрсдэлтэй хэвээр байсан. Энэ нь МКМ-ын зүгээс гамшгийн эрсдэлийг бууруулах ажлаа эрчимжүүлэн, цаашид тулгарч болох аюул эрсдлийг илүү сайн ойлгож, тэдгээрийг даван туулах арга хэмжээг хөгжүүлэн, малчид, бизнес эрхлэгчдэд ирээдүйд учирч болох эрсдэл, хямрал, хүндрэлтэй тэмцэхэд нь дэмжлэг үзүүлэхэд түлхэц болсон юм.

Монгол орон эрс тэс цаг агаар, аагим халуун зун, тэсгим хүйтэн өвлөөрөө алдартай бөгөөд энэ нь өргөн уудам нутагт тархан амьдрах 181 мянган малчин өрхүүдэд онцгой сорилт болдог. Орчин үед эдийн засаг, хүн ам зүйн хувьд ихээхэн өөрчлөлт гарч байгаа боловч уламжлалт Монгол ахуйг бэлчээрийн мал аж ахуйгаар төсөөлсөн хэвээр байна. Ган зудын улмаас мал бэлчээрлэх боломжгүй болоход малчдын амьжиргаа ноцтой хүндэрдэг. Цаг уурын эрс өөрчлөлт нь байгалийн гамшгийн хор уршгийг нэмэгдүүлж, давтамжийг ойртуулахад нөлөө үзүүлж байна. 2000 оноос хойш 21 сая толгой мал зуданд үхэж хорогдсон.¹ 1999-2002 оны хооронд дараалан тохиолдсон зудын улмаас Монгол улсын хэмжээнд 12 сая толгой мал хорогдсон нь тухайн үеийн нийт мал сүргийн бараг 30%-д хүрч байсан.²

Монголд малын тоо хэт өсч, улсын хэмжээнд бэлчээрийн даац 20-30%-аар хэтэрч, цаг уурын өөрчлөлтийн улмаас ган, зудны давтамж, хор уршиг улам ихсэх хандлагатай болсон. Бэлчээрийн даац хэтрэлт, талхагдал нь цөлжилт нүүрлэхийн үндсэн шалтгаан болж байна. Эдгээр хүчин зүйлүүд нь ган гачигнаас үүдэлтэй усны нөөцийн хомсдол, газар зохион байгуулалтын зохисгүй менежмент, мал эмнэлгийн үйлчилгээ хангалтгүй байгаа зэрэгтэй хавсран малын эрүүл мэнд, малчдын амьжиргаанд аюул учруулж байна.

МСМ нь төр, малчид, фермерүүд, малын эмч, иргэд болон онцгой байдлын ажилтнуудтай хамтран гамшгаас хамгаалах төлөвлөгөө, цаг агаарын мэдээ дамжуулах технологийн дэвшилтэт систем, шинжлэх ухааны үндэслэлтэй малын эрүүл мэнд, бэлчээрийн менежментийг хөгжүүлж нэвтрүүлсэн билээ.

Үр нөлөө: МОНГОЛЫН ЗАСГИЙН ГАЗАР АРД ИРГЭДЭЭ ДЭМЖИЖ, ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛСАН

Мерси Кор нь үндэсний хэмжээнд шинжлэх ухаанд суурилсан урьдчилан мэдээлэх системийг хөгжүүлж нутагшуулах ажлыг зохион байгуулсан

2001 оноос Монгол улс гамшгаас хамгаалах тогтолцоогоо сайжруулан, шинжлэх ухаанд суурилсан урьдчилан мэдээлэх системийг зудаас хамгаалах арга хэмжээнд нэвтрүүлж ирсэн билээ. Говийн Бэлчээр төслийн ололт амжилтанд тулгуурлан МКМ нь Монгол улстай хамтарч бүх аймгуудыг бэлчээрийн төлөв байдлын газрын зураг, цаг агаарын мэдээтэй холбох МААЭУМТ төслийг 2009 оноос хэрэгжүүлсэн. Бэлчээрийн зураг нь малчдад малаа бэлчээрлүүлэх, цаг агаарын аюултай үзэгдэлд бэлтгэхэд ихээхэн тус нэмэр болсон.

» Бэлчээрийн төлөв байдлын зураг нь малчдад өвс сайтай бэлчээр олоход тус болсон. Бэлчээрийн зураг ган, зуданд хамгийн ихээр өртсөн, мал сүрэгт нэмэлт тэжээл, тусламж шаардлагатай газар нутгийг харуулж байв.

» Телевиз, сонингоор малчид, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчид бэлчээрийн төлөв байдлын зураг авч ашиглаж байв. 160 гаруй малчдын хоршооны олон зуун гишүүд МААЭУМТ төслийн бүтээгдэхүүнийг ашигласан бол төрийн албан хаагчид байгалийн нөөцийг удирдах оновчтой шийдвэр гаргахад тус болох бодлогын түвшний сургалтад хамрагдсан.

1 Үндэсний статистикийн хороо, <https://www.1212.mn//>


2 НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, 2010, Dzud Early Recovery Program: https://info.undp.org/docs/pdc/Documents/MNG/00059396_Dzud%20early%20recovery_ProDoc.pdf

Малчид уламжлалт мэдлэгтэй тулгуурлан зуд болох нөхцөл байдал, зуданд өртөх хүчин зүйлүүдийг урьдчилан шинжиж мэддэг. Харин одоо орчин үеийн технологи дээр суурилсан онцгой байдлын тогтолцоог ашиглан Засгийн газар нь малчид иргэдэд гамшгийн эрсдлийг мэдээлэх замаар хариу арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах чадавхитай болсон. Малчдад цаг тухайд нь хэрэгтэй мэдээлэл хүргэх нь өвлийн бэлтгэлээ хангах, тулгарч буй аливаа саад бэрхшээлийг арилгахад тусалдаг.

Говийн Бэлчээр болон МААЭУМТ төслийг хэрэгжиж эхлэхээс өмнө гамшгийн бэлтгэл, төлөвлөлттэй холбоотой Монгол хэл дээр бэлтгэгдсэн судалгаа шинжилгээ, гарын авлага ховор байлаа. Гамшгийн бэлэн байдлыг хангах үүднээс МКМ “Зудыг давсан зузаан туршлага” эмхэтгэлийг малчдад зориулж хэвлүүлсэн. Энэхүү эмхэтгэлийг орон нутгийн 86 гаруй мянган иргэнд түгээсэн нь эрс тэс цаг уурын нөхцөлд малчдын бэлэн байдлыг дээшлүүлэхэд чухал алхам болсон билээ.

› МААЭУМТ төсөл шинжлэх ухаанд суурилсан цаг агаар, бэлчээрийн зургийг төрийн тогтолцоонд нэвтрүүлсэн

Анх МААЭУМТ технологийг Техасын ХАА-н судалгааны хүрээлэнгийн мэргэжилтнүүд Зүүн Африкт боловсруулж, Кени, Танзани, Уганда, Этиоп³ улсуудад амжилттай туршсан. МААЭУМТ технологи нь бэлчээрийн мониторингийн талбай байгуулан ургамлын гарцыг судалж, бэлчээрийн ургацыг урьдчилан харах арга зүй ашигладаг. PHYGROW буюу бэлчээрийн ургац тооцоолох загвар нь хөрс, бэлчээр, цаг агаарын мэдээлэл ашигладаг. Мэдээлэл цуглуулж, загвар боловсруулахад ахисан түвшний геостатистикийн аргачлалыг ашигладаг. Бэлчээрийн нийт ургац, олон жилийн дундажтай харьцуулсан бэлчээрийн төлөв байдал, бэлчээрийн ургац болон төлөв байдлын 60 хоногийн урьдчилсан мэдээлэл, малын тэжээллэг зэрэг мэдээллийг агуулсан багц зургууд сар бүр гардаг байсан. МААЭУМТ технологийг Цаг уур орчны шинжилгээний газар (ЦУОШГ)-т шилжүүлэн өгсөн.



Бэлчээрийн зураг. МААЭУМТ төслийн баг бэлчээрийн зургаар бэлчээрийн менежмент, өвс тэжээлтэй холбоотой мэдээллийг төрийн байгууллага, иргэдэд өгч байсан.

3 Техасын ХАА-н судалгааны хүрээлэн нь Техасын ХАА, Механикийн Их сургуулийн нэг хэсэг. Уг хүрээлэн нь докторын цолтой шилдэг эрдэмтдээс бүрддэг. Дараах сайтаас илүү дэлгэрэнгүй мэдээлэл авна уу: <https://cnrit.tamu.edu/index.php/mongolia-lews/>

Мерси Кор гамшгийн эрсдэл бууруулах төлөвлөгөө, журмын үндэсний стандартыг сайжрууллаа

МКМ нь LTS төслийн хүрээнд ОБЕГ-тай хамтран Мал сүрэгт тохиолдсон онцгой байдлын үед баримтлах заавар болон стандартууд (LEGS)-ыг танилцуулж нутагшууллаа. LEGS нь мал сүрэгт чиглэсэн үйл ажиллагаагаар дамжуулан гамшигт нэрвэгдсэн иргэдэд яаралтай тусламж үзүүлэх олон улсын заавар стандарт юм. LEGS гурван үндсэн зорилттой: яаралтай тусламж үзүүлэх, мал сүргийг хамгаалах, гамшигт нэрвэгдсэн орон нутгийн мал сүргийг нөхөн сэргээх. LEGS-ыг хэрэгжүүлсэнээр олон улсын стандартыг орон нутгийн удирдлага, малчдад таниулж, гамшгийн бэлэн байдлыг хангах үндэсний шинэ стандартыг бий болгосон юм. LEGS-ын хороо LEGS стандартыг Монгол хэл рүү орчуулах зөвшөөрлийг өгч, орчуулах ажлыг Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага (ХХААБ) санхүүжүүлсэн. Орчуулсны дараагаар ОБЕГ, МКМ, болон ХХААБ-аас хамтран Сургагч багш бэлтгэх сургалтад орон нутгийн ОБГ, сумдын ЗДТГ-ын ажилтнуудыг хамруулж, LEGS хэрэгслийг ашиглан гамшгийн төлөвлөлт, эрсдлийг бууруулах сургалт зохион байгуулах аймаг сумдын чадавхыг бэхжүүлсэн. ХХААБ-ын дэмжлэгтэйгээр LEGS сургалт маш өргөн хүрээг хамарсан бөгөөд ихэнх сумдууд гамшгийн төлөвлөгөөтэй болсон байна.

МКМ нь LTS II төслийн хүрээнд LEGS-ын дагуу боловсруулсан гамшгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн:

- › 4000 гаруй малчин, фермер, малын эмч, онцгой байдлын ажилтан LEGS стандартыг гамшгийн төлөвлөлтөд хэрхэн ашиглах талаар суралцав.
- › Орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшил, малчид гээд нийт 8000 гаруй иргэн 375 LEGS-ын сургалтад хамрагдсаны үр дүнд нь 292 сум гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөө LEGS стандартын дагуу шинэчилсэн.
- › 43 сум бэлчээрийн менежментийн төлөвлөгөө (БМТ) боловсруулсан нь БМТ загварыг улсын хэмжээнд нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулсан.
- › 100 сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг LEGS стандартад нийцүүлэн шинэчилж, хэрэгжүүлэхээр баталжээ.
- › ОБЕГ-д LEGS стандартыг нэвтрүүлж, Монгол улсад гамшгийн бэлэн байдлыг хангах жишиг стандарт болгон баталсан.

Үр нөлөө: МОНГОЛ УЛС МАЛ СҮРГИЙН БОЛОН БЭЛЧЭЭРИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛСАН

Мерси Кор Монголын Засгийн Газартай

Монголын Засгийн Газартай хамтран цаг агаарын мэдээг гар утасны мессежээр дамжуулах систем (SMS систем) бий болсон

LTS II төслийн хүрээнд Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ)-тай хамтран цаг агаарын мэдээ дамжуулдаг SMS систем бий болгож цаг агаар бэлчээрийн мэдээг малчдын гар утас руу шууд хүргэдэг боллоо. 2017 оны байдлаар, 50 гаруй мянган малчин уг SMS системийг ашиглан өдөр бүрийн амьдрал, ахуйгаа төлөвлөх боломжтой болсон. Тухайлбал гэр барих, нүүх, оторлох, хонины ноосоо хяргах, өвс хадах, ургац хураах гэх мэт. Үүнээс гадна, SMS систем нь фермерүүдэд ургац хураах хугацаагаа товлох, сургуулийн удирдлагад сурагчдаа байгалийн аюулт үзэгдлээс сэргийлж дотуур байранд байлгах шийдвэр гаргахад тустай байлаа.

Энэ SMS систем нь маш ир үр дүнтэй байсан тул Пийпл-Ин-Нийд, Их Британийн Сансар Судлалын Агентлаг болон Дэлхийн Хүнсний Хөтөлбөр зэрэг олон улсын байгууллагууд Мерси Кор, ОБЕГ-д хандан улсын эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, иргэдийн даван туулах чадварыг сайжруулахын тулд цаг агаарын мэдээ, бэлчээрийн төлөв байдал, үнэ ханшны мэдээг уг системээр дамжуулан түгээх хүсэлт тавьсан билээ.

2017 онд ОБЕГ үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч дөрвөн компанитай хамтран ажиллах гэрээ байгуулж, гар утасны аль ч дугаараас мессеж авах боломжтой тусгай дугаартай болсноор үүрэн холбооны үйлчилгээ илүү чанартай, хямд болсон байна.

Үүнээс хойш SMS системээр цаг агаар, бэлчээрийн төлөв байдал, зах зээлийн үнэ ханш зэрэг 12 төрлийн мэдээллийг darksky.net болон ЦУОШГ-аас авч түгээсэн. 2019 онд МКМ, ДХХ, ОБЕГ, ЦУОШГ болон Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) хамтарч SMS системээ улам өргөжүүлж, өвс тэжээл, хивэгийн зах зээлийн үнэ ханшийг хүргэх болов.

Талууд төсөл дууссаны дараа SMS системийг ОБЕГ-ийн эзэмшилд бүрэн шилжүүлнэ гэсэн тохиролцоотой байсан. 2018 оны 3 дугаар сард SMS системийг ОБЕГ-д албан ёсоор хүлээлгэн өгсөн. Үүний дараа МКМ-ын зүгээс шаардлагатай санхүүгийн дэмжлэг, телевизийн зар мэдээ боловсруулах болон сурталчилгааны бусад тусламжийг үргэлжлүүлэн үзүүлж байсан.

Мөн ОБЕГ-ын инженерүүдэд сургалт, техникийн тусламж үзүүлж байсан бөгөөд 2019 оны 12 дугаар сард сүлжээнд холбогдсон цахим мэдээлэл хадгалах төхөөрөмж, GIS компьютерыг хүлээлгэн өгсөн. SMS системийн цахим мэдээлэл хадгалах багтаамж, хүчин чадлыг өсгөж, серверийн ажиллагааг сайжруулдаг уг төхөөрөмжийг одоо ОБЕГ хариуцаж байгаа.




Фото зураг: Шон Шеридан (2017)

Архангай аймгийн Цэнхэр сумын малчин Гансүх, түүний гэргий Байгалмаа нар SMS системийг ашиглан мал маллагаагаа сайжруулж байна. Тэрээр “2009 оны зудаар бид мал сүргийнхээ 60%-ийг алдсан. Харин өнгөрсөн жилээс бид SMS системийг ашиглаж эхэлсэн тул манай алдагдал 15%-с доогуур байсан” гэжээ.

хамтран бэлчээрийн менежментийн арга барилыг хөгжүүлж хэрэгжүүлсэн.

Мал сүргийн тоо толгойн хяналтгүй өсөлт, бэлчээрийн зохисгүй менежментийн улмаас бэлчээрийн даац хэтэрч, цөлжилт нүүрлээд байна. Доройтсон бэлчээрээс мал сүрэг хэрэгцээт тэжээлээ авч чадахгүй байгаа бөгөөд халдварт өвчин тусах эрсдэл өндөр байна.

МКМ нь байгалийн нөөцийн менежментийн арга барилаар бэлчээр ашиглахын давуу талыг ойлгуулах, шилдэг туршлагаудыг нэвтрүүлэх гэж орон нутгийн төр иргэдтэй хамтран ажилласан. Жишээ нь МКМ орон нутгийн хөдөө аж ахуйн газруудтай хамтран ажиллаж, бэлчээрээ хаших, өнжөөх, сэлгээх, бордох замаар бэлчээрийн чанарыг сайжруулж болохыг харууллаа.

Мерси Кор малын эрүүл мэндийн бодлогыг сайжруулав

Хил дамжин халдварлах малын халдварт өвчний тархалт малчдын амьжиргаа, хүнсний аюулгүй байдалд ноцтой аюул учруулдаг. Малын халдварт өвчнийг хянахын тулд эрт илрүүлж, мэдээлэх нь маш чухал байдаг ч улирлаа даган алс хол нүүдэллэн амьдардаг, мал эмнэлгийн үйлчилгээнд байнга хамрагдаж чаддаггүй малчид үүнийг биелүүлэхэд хүндрэлтэй байдаг. Оролцооны аргаар халдварт өвчнийг тандан судлах (PDS) нь өвчнийг судлах, эрсдэлийг тандах, хянахад хэрэглэгддэг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хамгийн оновчтой арга юм. LTS II төслийн хүрээнд PDS аргачлалыг шинээр байгуулагдсан Мал Эмнэлгийн Ерөнхий Газар (МЭЕГ)-т танилцуулж малын гоц халдварт өвчний эрсдэл, үр нөлөөг бууруулах эхний алхамуудыг хийлээ. PDS нь малчид, малын эмч нарын оролцоо, мэдлэгийг ашиглан малын өвчнийг тандан судлах хамгийн тохиромжтой арга байв.

МЭЕГ-ын судалгааны ажилд нийт 2935 малчин оролцов. Өргөн уудам нутагт нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг



Зургийг: Шон Шеридан (2017)

Архангай аймгийн Цэнхэр сумын малчин Батсайхан. “Зудыг давсан зузаан туршлага” номноос өвлийн улиралд зориулж малын тэжээл хэрхэн бэлтгэх талаар сурсан.

Тэрбээр “2010 оны өвөл би мал сүргийнхээ 60% гаруйг алдсан. Малын хорогдол багассанаар сэтгэл санаа ч тайвширж байна” хэмээн хэллээ.

малчдад мэдлэг боловсрол олгох нь халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой байв.

- › LTS II болон LTS III төслүүдийн хүрээнд Монголд гэрчилгээтэй 4 PDS сургагч багш, 37 хэрэгжүүлэгч бэлтгэсэн. PDS-ыг анх танилцуулж байхад PDS-ын мэргэжилтэн Монголд байдаггүй байсан.
- › 2019 онд LTS III төслийн хүрээнд PDS-ийн аргачлалыг МЭЕГ улсын тандан судлах тогтолцоонд нэвтрүүлсэн. МКМ, МЭЕГ-тай Харилцан Ойлголцлын Санамж Бичиг байгуулсаны үндсэн дээр МЭЕГ нь PDS-ыг хариуцсан тусгай мэргэжилтэнтэй болж үндэсний хэмжээнд иргэд, малчид, малын эмч, төрийн албан хаагчдад сурталчлан таниулах үүрэг хүлээсэн байна.

PDS ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

PENAPH буюу Мал амьтан, нийтийн эрүүл мэндийн оролцооны эпидемиологийн сүлжээ нь PDS-ийг хэрэгжүүлэгч, сургагч багш болон мастер сургагч багш нарыг PDS-ийн аргачлалд сургаж, гэрчилгээжүүлэх үйл явцыг хариуцдаг олон улсын байгууллага юм. PDS хэрэгжүүлэгч нь PDS аргачлалыг эзэмшсэн, малчид, иргэдтэй хамтран малын өвчнийг илрүүлэх, хянах чадвартай мэргэжилтэн юм.

PDS хэрэгжүүлэгч болоход дараах шаардлага тавигдана:

1. PDS-ыг танилцуулах сургалтанд оролцох (10 өдөр)
2. PDS-ын орон нутгийн судалгаа хийх (20 өдөр)
3. PDS-ын давтан сургалтад хамрагдах

PDS сургагч багш гэдэг нь Мастер багшаас сургагч багшийн гэрчилгээ авсан малын эмч юм. Сургагч багш нь PDS хэрэгжүүлэгчдийг бэлтгэж, гэрчилгээжүүлэх ажлыг хянаж хариуцдаг.


Сургагч багш болоход дараах шаардлага тавигдана:

1. PDS хэрэгжүүлэгч байх
2. Сургагч багшийн сургалтад хамрагдах (6 өдөр)
3. Мастер багшийн удирдлаган дор PDS-ын үндсэн сургалтыг зохион байгуулах

PDS-ын салбарт нилээн хэдэн жил ажилласан, өөр нэг мастер багшаас PENAPH сүлжээнд санал болгож, нэрээ дэвшүүлсэн сургагч багшийг Мастер багш гэж хэлдэг. Одоогоор Монголд бэлтгэгдсэн мастер сургагч байхгүй байна.

Орон нутгийн иргэдэд цаг агаар, зах зээлийн мэдээлэл дамжуулах системийн хөгжил

МКМ ган, зудаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын хүрээнд цаг агаарын мэдээллийг газрын зургаар анх дамжуулж эхэлсэн нь SMS системийг байгуулах анхны алхам байлаа. Дараа нь бусад төсөл, хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төр, иргэний нийгэм, иргэдтэй хамтран ажилласны үр дүнд бэлчээр, малын эрүүл мэнд, зах зээлийн үнэ ханшийг түгээж эхэлсэн.




Мэдээлэл дамжуулах системийн хөгжил



Хасуу Шивэрт цогцолборт Мерси Корын ажилтнууд 4 аймгийн 60 малчдад зориулж малын эрүүл мэндийн сургалт зохион байгуулж байна.

Фото зураг: Шон Шеридан (2017)



Мерси Кор Монголд 1999 онд анх орж ирэхэд ардчилсан шинэ засаг нь иргэний нийгмийн талаар ойлголт багатай байв. Иргэд нь шийдвэр гаргах үйл явцад бага оролцдог нь эдийн засагт сөргөөр нөлөөлдөг. Ялангуяа хөдөө орон нутагт засаг, ИНБ-ууд нь иргэдтэйгээ хөгжлийн бодлого, иргэдийн амьжиргаа, төрийн үйлчилгээний талаар зөвлөлдөж чаддаггүй учир энэ байдал их хурцаар мэдрэгддэг. Мерси Кор нь иргэний нийгэм байгуулах, төрийн үйл ажиллагааг сайжруулах, иргэдэд ээлтэй, хүртээмжтэй бодлого хэрэгжүүлэх, иргэдийн оролцоог хангасан, ил тод, нээлттэй аргаар авлигыг бууруулах, иргэдэд эрх үүрэг, нөлөөллийн талаар танилцуулах зэрэг ажлыг орон нутгийн түншүүдтэйгээ хамтран хэрэгжүүлсэн.

“Сургалт, Нөлөөлөл ба Хамтын Ажиллагааны Сүлжээ” төсөл (TAN төсөл) Төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, олон нийтэд үзүүлэх төрийн үйлчилгээг сайжруулах, иргэдтэй ажиллах, ИНБ-ын сүлжээ байгуулах зорилгоор орон нутгийн ИНБ-ын чадавхыг хөгжүүлсэн.

“Засаглалын хариуцлагатай байдлыг сайжруулах төсөл - 2” (BRICS-II) Цахим бүртгэлийн систем нэвтрүүлж, ХБИ-д зориулсан нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулснаар анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлж, нээлттэй ил тод төрийн худалдан авах ажиллагааг дэмжсэн.

“Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх II” төсөл (FIELD II) ХБИ-ийн байгууллагуудтай хамтран хүртээмжтэй байдлын улсын стандартыг хэрэгжүүлэх, иргэдэд таниулах, ХБИ-ийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, ХБИ-д сонгуульд оролцох боломжийг нь бүрдүүлсэн.

2000

2005

2010

2015

2020

“Засаглалын хариуцлагатай байдлыг сайжруулах төсөл” (BRICS I) Төсвийн зарцуулалтыг хянах, эрүүл мэндийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх, ИНБ, төрийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаагаар төр, хувийн хэвшил, иргэний нийгэм хоорондын нээлттэй, ил тод, бүтээмжтэй харилцааг хөгжүүлсэн.

“Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх төсөл” (FIELD төсөл) ХБИ-ийн Эрхийн талаарх НҮБ-ийн конвенцийн зарчим, заалтуудыг зам тээвэр, боловсрол, барилгын тухай Монгол улсын хуулиудад тусгасан.

“Нийгмийн хамгааллын сүлжээ төсөл” Эмзэг бүлгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн амьдралд тэгш хамрагдах байдлыг нэмэгдүүлж, дэлхийн санхүүгийн хямрал, 2010 оны зуднаас учирсан хохирлыг багасгахад туслалцаа үзүүлсэн.

“Төрийн худалдан авах ажиллагааны ил тод өрсөлдөөнт тогтолцоог бэхжүүлэх төсөл” (ICOGS) Төсөв захиран зарцуулах гол нэгжүүдийн чадавхийг бэхжүүлэх, худалдан авах ажиллагаан дахь ИНБ-ын оролцоог дээшлүүлэх, хувийн хэвшилд тендерийн материалуудыг бэлтгэхэд тусламж үзүүлэх замаар төрийн худалдан авах ажиллагааны ил тод өрсөлдөөнт тогтолцоог бэхжүүлсэн.

“Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх итгэлтэй түншлэл ба иргэдийн оролцоо төсөл” (APPEAL) Сайн засаглалын талаархи иргэдийн мэдлэг боловсрол, оролцоог нэмэгдүүлж, орон нутгийн засаг захиргаатай хамтран авилгын эсрэг төлөвлөгөө хэрэгжүүлж, сайн засаглал, авилгын эсрэг үйл ажиллагааг дэмжих аян зохион байгуулан 15 аймагт сайн засаглалыг бэхжүүлсэн.



САЙН ЗАСАГЛАЛ

Мерси Кор иргэний нийгэм, төрийн байгууллагуудыг чадавхжуулж, ил тод, хариуцлагатай, иргэдийн оролцоог хангасан бодлого, арга барилыг нэвтрүүлсэн.

МКМ-ын бүх төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болгосон төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хоорондын түншлэл нь орон нутгийн иргэдийн хэрэгцээг хангах, тогтвортой эдийн засгийн хөгжлийг дэмжих ээлтэй орчин бүрдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байсан. Иргэдийн дуу хоолойг эдийн засгийн хөгжил, гамшгийг бууруулах бодлого стратегид тусгаж, нийгмийн бүх шатанд олон нийтийн хамтын ажиллагааг бий болгохын тулд МКМ нь засаглалыг сайжруулах, нээлттэй, ил тод төрийн тогтолцоог бэхжүүлэх, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг зорьдог.

Жижиг тэтгэлэг, иргэний нийгмийг бэхжүүлэх сургалт, хөдөө орон нутгийн төр, иргэдтэй ажиллах ИНБ-ын сүлжээ байгуулсаны үр дүнд төр ИНБ хоорондын хамтын ажиллагаа бэхжиж, улмаар иргэдийн оролцоо нэмэгдэж, сайн засаглалыг дэмжсэн билээ.

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас ардчилсан нийгэм, чөлөөт зах зээл рүү шилжих эмзэг үед МКМ сайн засаглалын хөтөлбөрүүдээ хэрэгжүүлж эхэлсэн. ИНБ-уудтай хамтран нийгмийн хамгааллыг сайжруулж, төрийн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналтыг дээшлүүлсэн нь орон нутагт нийгмийн сүлжээг бэхжүүлэх, төр иргэдийн хоорондын харилцаа холбоог сайжруулахад хувь нэмрээ оруулсан билээ. МКМ-ын ТАН, APPEAL хөтөлбөрүүд ИНБ-уудтай ажиллаж, авилгалын эсрэг үйл ажиллагаа, нээлттэй ил тод байдлыг дэмжсэн; ICOGS болон BRICS хөтөлбөрүүд ИНБ-уудтай ажиллаж төсвийн ил тод байдал, нээлттэй худалдан авах ажиллагаа, иргэд төрийн хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлсэн. Иргэдийн сайн засаглалын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх нь засаглалыг сайжруулах гол хүчин зүйл болдог.

Засаглал гэдэг нь шийдвэр гаргах болон гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх үйл явц гэж Мерси Кор үздэг. Ил тод, хариуцлагатай, шударга, оролцоог хангасан тогтолцоо, үйл явц бий болсон үед сайн засаглал бүрэлдэнэ.

Үр нөлөө: ИРГЭНИЙ НИЙГЭМ БЭХЖИЖ, ТӨР ИРГЭДИЙН ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА САЙЖИРСАН

Мерси Кор нь ур чадвар, хамтын ажиллагааг сайжруулах замаар ИНБ-уудын чадавхыг бэхжүүллээ

2003 онд МКМ төр, иргэдтэй хамтран ажиллаж, нөлөөллийн үйл ажиллагаа гүйцэтгэх чадвар бүхий хөдөө орон нутгийн иргэний нийгмийг байгуулахыг зорьсон “Сургалт, нөлөөлөл ба хамтын ажиллагааны сүлжээ” ТАН төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

ТАН төслийн үр дүнд:

- › МКМ нь ИНБ-ын албан бус сүлжээг зорилтот таван аймагт байгуулсан. ТАН хөтөлбөр хэрэгжихээс өмнө ИНБ-ууд бие биеэ ямар үйл ажиллагаа хэрэгжүүлдэг талаар сайн мэддэггүй байсан. ИНБ-ын сүлжээг байгуулснаар тэд хоорондоо танилцаж, туршлагаа солилцож, нөлөөллийн ажлуудаа хамтран хийх болсон.
- › ИНБ-уудыг төр, хувийн хэвшил, иргэдтэй хамтран ажиллахад нь зөвлөгөө өгөх зорилгоор орон нутгийн зөвлөхүүдийг бэлтгэсэн. Үүний үр дүнд ИНБ-ууд нь санхүүжилтээ босгох, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, стратеги төлөвлөх, байгууллага удирдах, зорилтот бүлэгт үйлчилгээ үзүүлэх гээд өөрсдийн ур чадвараа дээшлүүлсэн.

Мерси Кор нь ИНБ-дад дэмжлэг үзүүлснээр төр иргэд хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, хариуцлагатай, нээлттэй байдлыг хөхүүлэн дэмжсэн

ТАН төсөл ИНБ-уудтай хамтран ажиллаж, төрийн байгууллагуудтай түншлэл тогтоох, төрийн ажил, төсвийн зарцуулалтанд иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлсэн.

МКМ-ын сайн засаглалын хөтөлбөрүүдийн нийтлэг шинж нь бодит жишээн дээр тулгуурлаж сайн засаглалын давуу талыг харуулахаас гадна төрийн тогтолцоог хэрхэн илүү нээлттэй, хариуцлагатай болгож болохыг үзүүлэх явдал байлаа. Үр дүнд нь иргэний нийгмийн салбар дахь оролцогчдын төр, хувийн хэвшилтэй хамтран ажиллах чадавхи сайжирсан юм.

МКМ-ын хөтөлбөрүүдээс тэтгэлэг авсан ИНБ-ууд нь жижиг бизнесийн орлогыг нэмэгдүүлэх, олон нийтийн хөрөнгийн зарцуулалтыг илүү үр дүнтэй болгох, иргэдийг эрхээ хамгаалах мэдлэг, итгэлтэй болгох чиглэлээр төр, иргэдтэй ажиллаж, иргэдийн оролцоог бодитоор хангаж ирсэн билээ. Ялангуяа, BRICS-ын төслүүд сайн засаглалыг дэмжих, орон нутагт тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог хангах шинэлэг арга барилуудыг танилцуулсан билээ.

BRICS төслөөс сургуулийн үдийн цайны хөтөлбөрийн төсвийн хяналтад иргэдийн оролцоог хангахад дэмжлэг үзүүллээ. Иргэд анх удаа сургуулийн үдийн цайны

Нээлттэй худалдан авах ажиллагааг дэмжсэн гурван талт түншлэл

ТАН төслийн хүрээнд гурван талт түншлэл байгуулж иргэдийг ИНБ болон төрийн байгууллагуудтай холбосон. Гурван талт түншлэл гэдэг нь хувийн хэвшил, иргэдийн хурлын төлөөлөгчид хамтран төрийн мөнгөний зарцуулалтад хяналт тавьдаг хороо юм. МКМ-ын байгуулсан гурван талт түншлэл нь төр, хувийн хэвшил, иргэд хоорондоо нээлттэй харилцаж, эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлж байсан. Энэ нь бизнесийн орчныг сайжруулж, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, төр бизнес аль аль нь илүү хариуцлагатай, ил тод ажиллах чадвартай болоход нөлөөлсөн билээ. Гурван талт түншлэл нь иргэний нийгмийг төлөөлж нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд бүх талын оролцоог хангаж чадах маш чухал хэрэгсэл байсан. BRICS I төслийн хүрээнд “Орон нутгийн санаачлага” ИНБ-ыг дэмжиж, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн худалдан авах ажиллагаанд хяналт тавих Гурван талт түншлэл байгуулахад тусалсан.

МЕРСИ КОР МОНГОЛЫН САЙН ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



ГОЛ АМЖИЛТУУД

- НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД, ӨРСӨЛДӨӨНТ ТӨРИЙН ХУДАЛДАН АВАЛТ
- АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
- НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СҮЛЖЭЭ
- ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД ӨРСӨЛДӨӨНТ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ
- ХБИ-ИЙН ХҮРТЭЭМЖИЙН СТАНДАРТУУД
- ХӨДӨӨГИЙН ИРГЭДЭД ЗОРИУЛСАН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Фото зураг: Тэтчер Кук (2008)

ТАН төсөл орон нутгийн ИНБ-д ажилгүйдлийг бууруулах хүрээнд тэтгэлэг олгов. Тэтгэлэг авч хэрэгжүүлсэн нэг жишээ бол Үйлдвэрчний Эвлэлийн “Гоёл” оёдлын цехэд үзүүлсэн дэмжлэг юм.

*Архангай аймгийн Цэцэрлэг сумын оёдолчин
М.Бадамханд*

төсөв, хэрэгжилттэй холбоотой ярилцлага, хэлэлцүүлэгт оролцож эхэлсэн. Энэхүү ажиллагаанд иргэдийн оролцоо нэмэгдэж, улам нээлттэй болсны үр дүнд сургуулийн үдийн цайны чанар нь дээшилсэн. Энэ нь төрийн худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод, өрсөлдөөнт хэлбэрээр зохион байгуулахын ач холбогдлыг харуулсан юм. Сургуулийн үдийн цайны хөтөлбөрт бүтээгдэхүүн нийлүүлэхэд илүү олон компани өрсөлдөх боломжийг хангах заалтуудыг тусгасан.

BRICS төслийн хүрээнд сургуулийн Үдийн цайны хөтөлбөрт нээлттэй, өрсөлдөөнт худалдан авах ажиллагааг нэвтрүүлсэн. Өрсөлдөөнт худалдан авах ажиллагааг Үндэсний чуулган зохион байгуулж, сурталчилгааны материалаар түгээх замаар бусад аймгуудад танилцуулсан. Худалдан авах ажиллагаанд бизнесүүд оролцох боломжтой болохоос гадна үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх сонирхолтой болсон.

“Тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх чуулга уулзалт зохион байгуулахдаа бид Сангийн яамыг оролцуулсан. Үр дүнд нь Сангийн яам цахим худалдан авалтын вэб хуудас бүтээж, худалдан авах ажиллагаагаа ил тод болгосон. Үүнээс хойш тэд бүх тендерээ болон тендерт шалгарсан бүх байгууллагуудыг энэ хуудсаар зарладаг болсон. Ингэснээр яамны болон орон нутгийн худалдан авах ажиллагаа ил тод болсон.”

У. Мандал, МКМ-ын Иргэний нийгэм хариуцсан захирал (2005 -2011)

Үр нөлөө: ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭД ТӨРИЙН БОДЛОГОД НӨЛӨӨЛӨЛ ҮЗҮҮЛСНЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛГОХОД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛСАН

Мерси Кор төрийн байгууллагуудтай хамтран эмзэг бүлгийн иргэдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэхийг дэмжсэн

2001-2008 онд Монгол улсын эдийн засаг хурдацтай хөгжиж байсан үе. Гэвч 2008-2009 онд дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямрал бий болж Монголын эдийн засагт ч хүндээр туссан. Түүхий эдийн үнэ унаж, зээл авах боломжгүй болсоны улмаас орон нутгийн олон жижиг бизнесүүд дампуурч, малчдын амжиргаа буурсан. Үүнээс гадна Монголд 2009 онд зун ган гачиг, 2009-2010 оны өвөл зуд турхан тохиож, 2010 оны 5-р сарын байдлаар 8.2 сая толгой мал (улсын хэмжээнд нийт мал сүргийн 26%) хорогдсон билээ. Энэ нь хөдөөгийн эдийн засагт хүнд цохилт болсон бөгөөд орон нутгийн олон иргэдийн амьжиргаа буурч, тэдний 50% орчим албан ёсоор “ядуу” гэх ангилалд багтах болов. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг нь (ОУХА) дэлхийн санхүүгийн хямралыг давж, зудын гамшгийн хохирлыг бууруулах зорилгоор Монгол улсад санхүүгийн тусламж олгосон билээ.

АНУ-ын ОУХА-ын санхүүжилтээр Мерси Кор “Нийгмийн хамгааллын сүлжээ” төслийг зорилтот арван аймагт хэрэгжүүлсэн.

Нэг, хоёрхон тулгамдаж буй асуудлыг шийдэхийн оронд, МКМ бүх оролцогч, үр шим хүртэгчдийг хамруулсан нэг жилийн эрчимжүүлсэн стратеги аргачлалыг боловсруулан уг төслийг хэрэгжүүлсэн билээ.

Төслийн гол амжилт нь эмзэг бүлгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн амьдралд тэгш хамрагдах байдлыг сайжруулж, улмаар эдийн засаг, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх үйл ажиллагааг тусгайлан боловсруулж, танилцуулж, Монголын талд шилжүүлж өгсөн явдал байлаа.

4075 хүн мэргэжлийн чиг баримжаа олгох дамжааг дүүргэснээс 2041 нь байнгын болон түр ажлын байртай болсон байна

Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд 3056 эмэгтэйчүүд хамрагдаж, 1595 эмзэг бүлгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүс байнгын ажилтай болж, 362 нь өөрийн бизнесийг эхлүүлсэн байна.

ХНХЯ-тай Хамтран ажиллах санамж бичиг байгуулан, мэдээлэл тогтмол солилцож, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах замаар төслийн сургалтуудыг төрийн тогтолцоонд нэвтрүүлсэн бөгөөд “Нийгэм эдийн засгийн амьдралд тэгш оролцох” аргачлалыг (ялангуяа нийгэм сэтгэл зүйн сургалт) 2012 онд Засгийн газар Улаанбаатар хот, аймгийн төв, сумдад “Гэр бүлийн хөгжлийн дэмжлэг” хөтөлбөрт нэвтрүүлэхээр баталсан байна.

Мерси Кор нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн (ХБИ) хүртээмжтэй байдлыг хангахаар Монгол улстай хамтран ажиллалаа

Монголд ХБИ-д тулгарч буй гол асуудал нь төрийн үйлчилгээ мэдээллийн хүртээмжгүй байдал, үүний дотор боловсрол, эрүүл мэнд, нийгмийн болон бусад үйлчилгээнд хамрагдах боломжгүй байх явдал юм. Мерси Корын тавьсан нэг томоохон зорилт нь “Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх” (FIELD) төслийн хүрээнд ХБИ-ийн эрхийн тухай НҮБ-ийн конвенцийн зарчим, заалтуудыг Монголын хууль, тогтоомжтой нийцүүлэх ажил байлаа. МКМ нь BRICS II төслийн хүрээнд Нийгмийн Халамжийн Газартай хамтран ХБИ-дэд хүргэх нийгмийн халамжийн үр нөлөөг дээшлүүлэх ажлыг гүйцэтгэсэн. FIELD төслийн хүрээнд нийгэм-эдийн засгийн амьдралд ХБИ-д саад бэрхшээлгүйгээр оролцох, нийгмийн хандлага, хууль эрх зүйн болон дэд бүтцийн хүртээмжтэй байдлыг бий болгосон.

Өнөөгийн хууль тогтоомжинд ХБИ боловсрол эзэмших, ажил эрхлэх, нийгмийн үйлчилгээг авах эрхтэй гэсэн заалттай ч хуулийг хэрэгжүүлэх механизм өөрөө сул тул Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Нэгдсэн Холбоо (МХБИНХ) болон ХБИ-ийг дэмжих ажлын хэсэг нь үйл ажиллагаагаа явуулахад хүндрэлтэй байсан. FIELD- I ба II төслүүдийн үр дүнд:

- › “Иргэний барилга болон замын төлөвлөлтөнд ХБИ-ийн шаардлагыг хангах заавар стандартууд” батлагдсан. Үүнээс хойш бүхий л дэд бүтцийн зураг төсөлд ХБИ-ийн хэрэгцээг тооцох шаардлагатай болсон билээ.
- › 670 төрийн албан хаагч, инженер, хот төлөвлөгч, бодлого боловсруулагчдыг ХБИ-ийн Эрхийн тухай зарчим, хүртээмжтэй байдлын үзэл санаа, ерөнхий төсөл, хүртээмжтэй байдлыг хангах улсын стандартын сургалтанд хамрууллаа.
- › ХБИ-ийн байгууллагуудаас бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан ХБИ-ийн эрхийг хамгаалах төрөл бүрийн арга хэмжээ авсан.
- › ХБИ-д зориулсан хүртээмжтэй байдлын стандартууд, чадавхи бэхжүүлэх арга хэмжээ, эмзэг бүлгийн иргэдэд зориулж бизнесийн боломж шинээр бий болгох, олон нийтийн ойлголт мэдлэг дээшлүүлэх аян зохиосноор 13 гаруй мянган иргэд үр шим хүртсэн.

Үр нөлөө: ТӨР БОЛОН ИНБ-УУД АРДЧИЛАЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЧАДАВХАА БЭХЖҮҮЛЛЭЭ

Мерси Кор нь иргэд, ИНБ-уудын чадавхжуулах замаар төр захиргааны авилгын эсрэг төлөвлөгөөг сайжруулсан.

Монгол улс олон улсын зах зээлд нэгдсэн нь шинэ боломж бололцоог нээхийн зэрэгцээ ажилгүйдэл, баян

ядуугийн ялгаа зэрэг нийгмийн асуудлууд шинээр гарч, иргэдээ дэмжих эдийн засгийн шинэ бодлого хэрэгжүүлэх шаардлагатай болсон юм. ТАН төслийн хүрээнд эхлүүлсэн ажил дээр тулгуурлан МКМ-ын “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо” (APPEAL) төсөл нь авилгын эсрэг, сайн засаглалтай холбоотой хууль эрх зүйн орчны тухай ойлголтыг бэхжүүлж, орон нутгийн иргэдийн оролцоог дэмжин ажиллав.

- › APPEAL төсөл 15 аймгийн ИНБ-уудын сайн засаглалыг дэмжих үр чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн 111 жижиг тэтгэлэг олгосон. Үр дүнд нь олон талт түнш байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн баг 3388 арга хэмжээ зохион байгуулж, нийт 496476 иргэн үр шим хүртсэн.
- › APPEAL төсөл Монголын 126 төрийн болон төрийн бус байгууллагуудтай ажилласан бөгөөд үүнээс 119 нь ИНБ байсан. APPEAL нь сайн засаглал, авилгатай холбоотой хууль тогтоомжийг сайн мэддэг, төрийн үйл ажиллагааг сайжруулах, авилгыг арилгах арга зүйг эзэмшсэн олон мэргэжилтнүүдийг төслийн үйл ажиллагаанд татан оролцуулав.
- › APPEAL төслийн “Хууль дүрэм бодит амьдралд” аяны хүрээнд зохион байгуулсан 192 арга хэмжээнд 29224 иргэн хамрагдаж, сайн засаглалын талаарх ойлголтоо дээшлүүлэв. Орон нутгийн оролцогчид засаглалын гол хуулиудын талаар ойлголтоо сайжруулсан нь салбар хоорондын хамтын ажиллагааг илүү үнэлэх, засаглалын үйл явцад оролцох сохирхол, төрийн байгууллагуудтай холбогдох боломж нь ихэссэн.

Мерси Кор нь нээлттэй, өрсөлдөөнт, ил тод төрийн худалдан худалдан авах ажиллагааг дэмжсэн

BRICS төслийн хүрээнд анх хэрэгжүүлсэн нээлттэй, ил тод худалдан авах ажиллагааг “Хөдөөгийн бизнес эрхлэгчдэд олгох зах зээлийн боломжууд” (Зах зээлийн боломжууд) төслийн хүрээнд үргэжлүүлж, түншлэлийн тоо, иргэний нийгмийн хяналт, орон нутгийн худалдан авах боломжуудыг улам нэмсэн. “Зах зээлийн боломжууд” төсөл төрийн худалдан авах ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулахын зэрэгцээ иргэдийн оролцоог дээшлүүлж, орон нутгийн бараа, үйлчилгээний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлсэн билээ. Төрийн албан хаагчид худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод байдлаар хэрэгжүүлэх үр чадвартай болж, иргэний нийгмийн гишүүд тендерийн үнэлгээний хороонд ажиллах буюу бие даасан ажиглагчаар оролцох мэдлэгтэй болж, бизнесүүдийн тендерийн баримт бичгийг боловсруулах чадвар сайжрав. Гурван талт хороо болон худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг хэмжих индексийн үнэлгээгээр дамжуулан “Зах зээлийн боломжууд” төсөл иргэдийг чадавхжуулж, төрийн үйл ажиллагаа, хариуцлага хүлээх тогтолцоог хянах боломж олгосон.

- › “Зах зээлийн боломжууд” төсөл худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод, өрсөлдөөнт байдлыг

хэмжих COGS индекс боловсруулсан. Төрийн бүх тендерт COGS индекс нь 94% (зорилтот 70%-ийг давуулан биелүүлж) хүрсэн нь төрийн бараа, үйлчилгээ худалдан авах, гэрээ байгуулах үйл явцыг улам нээлттэй, ил тод болгож чадсаныг харуулж байна.

- › “Зах зээлийн боломжууд” төслийн хүрээнд орон нутгийн 952 бизнес тендерт оролцож, 564 бизнес шалгарч, нийт 7 сая ам.долларын төсөв бүхий 753 гэрээг байгуулжээ.
- › Нээлттэй, ил тод тендерт оролцсон бизнесүүд орон нутгийн бараа ажил үйлчилгээний хэрэгцээг хангах зорилгоор үйл ажиллагаагаа өргөтгөж, 12 аймагт нийт 429 ажлын байрыг шинээр бий болгов.

Төрийн худалдан авах ажиллагааны ил тод өрсөлдөөнт тогтолцоог бэхжүүлэх (ICOGS) төсөл нь BRICS болон “Зах зээлийн боломжууд” төслийн худалдан авах ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн.

- › ICOGS төслийн хүрээнд 13 аймгийн 969 ажилтан МКМ-ын худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад хамрагдаж 378 тендерийг үнэлэх хороонд (ТҮХ) ажиллав.

- › ICOGS төсөл 200 гаруй тендерийн сургалт зохион байгуулж, төсөв болон худалдан авах ажиллагааны ил тод байдал, хяналтыг сайжруулж, төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжсэн. Үүнд ТҮХ-ны гишүүд, хэвлэл мэдээллийн төлөөлөгчид, ИНБ-уудын гишүүд зэрэг нийт 6000 гаруй хүн оролцсон.

- › 2013-2014 онд 147435 иргэн олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх аянд хамрагдаж, төсвийн ил тод байдал, сайн засаглал, төсөв боловсруулах чиглэлээр мэдлэгтэй болсон. Уг арга хэмжээ нь худалдан авах ажиллагааг үр дүнтэй явуулах, нээлттэй тендерийн ач холбогдол, иргэдийн оролцоог хангахад төрийн үүрэг хариуцлага зэрэг сэдэвт анхаарлаа хандуулсан. Оролцогчид нь орон нутгийн худалдан авалтын алба, ИТХ, ЗДТГ, ИНБ-уудын төлөөллүүд, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд байлаа.

МКМ нь орон нутгийн ИНБ-уудын чадавхыг дээшлүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн тогтолцоог бэхжүүлэх замаар худалдан авах ажиллагааг сайжруулан, ил тод засаглалыг дэмжих ажиллагааны үр дүнд төрийн тендерт оролцож шалгарсан орон нутгийн бизнесүүдийн тоо нэмэгдсэн.



Фото зураг: МЕРСИ КОР

“FIELD-II төслийн хүрээнд 2011 онд баригдсан шинэ барилгуудын ХБИ-д хүртээмжтэй байдалд үнэлгээ хийлээ. Энэ үеэр төслийн хүрээнд дэд бүтцийн хүртээмжтэй байдалд техникийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулах чиглэлээр техникийн зөвлөгөө авсан байсан. Үр дүнд нь бид мэргэшсэн баг, техникийн үнэлгээний аргачлалтай болсон. 2013 онд бид Үндэсний Тэргэнцэртэй Иргэдийн Холбоог байгуулж, аймгуудад салбаруудаа нээсэн. 2020 оны байдлаар манайх 7 салбартай болсон. Үүнээс 5 салбарт нь ХБИ-ийн хүртээмжийн судалгааг гүйцэтгэх чадвартай мэргэжилтнүүд ажилладаг.”

Б.Чулуундолгор, Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбооны захирал



Фото зураг: Шон Шеридан (2017)

Мерси Кор Монгол багийн ололт амжилт

Мерси Корын үлдээж буй үнэт өвийн чухал хэсэг нь амжилт гаргахад шийдвэрлэх хувь нэмэр оруулсан Монголын болон олон улсын 300 гаруй орчим ажилтан, мэргэжилтнүүд юм. Ажилласан хугацаанаас үл хамааран МКМ-ын ажилтнууд Монголын хөдөө орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулахад оруулсан хувь нэмэр, хүчин зүтгэлээрээ бахархдаг. Мерси Кор нь МКМ-ын нийт бүх ажилтнууддаа чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн зэрэгцээ Монголд хорь гаруй жил төсөл хөтөлбөрүүдээ саадгүй хэрэгжүүлж, шинэлэг зүйл бүтээх боломж олгосон МКМ-ын анхны Суурин төлөөлөгч Стефэн Д. Вэнсэд гүн хүндэтгэл илэрхийлж байна.

“Бид Монголын хөдөөгийн иргэдэд эерэг өөрчлөлт авчирсан олон гайхалтай ажлыг хэрэгжүүлсэн билээ. Би хуучин МК-оос зээл авсан харилцагчидтай 10 жилийн дараа уулзахад ч тэд бизнесээ хөгжүүлж, амьдралаа өөрчлөх боломж олгосонд бидэнд талархалаа илэрхийлсээр байдаг.”

Г. Ганхөлөг, Гүйцэтгэх захирал, Отгон уулын элч ХХК (МКМ 2006-2012)

“МК-ын бүхий л төсөл, хөтөлбөрүүд эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог сайжруулах, эмзэг бүлгийнхэнд нийгмийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх замаар бүх Монголчуудын амьдралд шууд нөлөөлсөн юм.”

У. Мандал, Иргэний нийгмийн хэлтсийн захирал (МКМ 2005-2011)

“Монгол Улсын хөгжилд томоохон нөлөө үзүүлсэн олон улсын байгууллагад ажиллаж байснаараа би үргэлж бахархдаг. МК хөдөө орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулж, ЖДУ-ийн өрсөлдөх чадавхыг дээшлүүлэн, төр ИНБ хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлсэн билээ.”

Х. Төртогтох, Ахлах эдийн засагч Өндөр Алтайн Зам ХХК (МКМ 2007-2014)

Мерси Кор Монгол ОУБ үйл ажиллагаагаа өндөрлөлөө

Монгол улс 30 жилийн өмнөөс ардчилсан тогтолцоо руу шилжиж эхэлсэн билээ. Өнөөгийн Монгол улс нь хүчтэй, идэвхтэй иргэний нийгэмтэй, эрчимтэй хөгжиж буй хувийн хэвшилтэй, хариуцлагатай, бүх талын оролцоог хангасан төртэй, дундаж орлого бүхий иргэдтэй улс болсон байна.

Иймээс 2021 оны 3 дугаар сард RCP хөтөлбөр дуусмагц Мерси Кор үйл ажиллагаагаа зогсоож, Монголоос гарах шийдвэрээ 2020 оны сүүлчээр зарласан билээ. Энэ бол хөгжлийн салбарт тохиолддог хэвийн үзэгдэл. Учир нь Монголд хөдөөгийн зах зээл хөгжиж байна, томоохон ТББ Монголоос гарч, зам тавьж өгч байгаад Монголын иргэний нийгэм нь бэлэн байгаа, төр нь байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай, уян хатан шинж чанартай бизнесийн өсөлтийг дэмжих орчин бүрдүүлсэн гэж хэлж болно.

Сүүлийн 20 жилийн турш МКМ нь Монгол улсын Засгийн Газар, орон нутгийн ИНБ-ууд, хувийн хэвшилтэй хамтран мал аж ахуй, боловсрол, засаглалын салбарт үр нөлөөтэй хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж иржээ. Энэ хугацаанд бид төрийн бүх түвшний байгууллагуудтай хамтран ажиллаж, нарийн төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэж, хөдөө орон нутгийн иргэд малчдыг төртэй ойртуулахын төлөө хичээж зүтгэсэн билээ.

Бид Монгол Улсад хийж гүйцэтгэсэн ажил үйлс, бүтээсэн зүйлс, гаргасан үр дүн, ололт амжилтаараа маш их бахархаж байна. Бид энэ хугацаанд 60 сая ам.долларын тусламж хүргэж, 25 гаруй төсөл хөтөлбөрийг Монгол улсын бүх аймагт хэрэгжүүлсэн. Манай хамт олон эрхэм зорилго, итгэл үнэмшилдээ чин үнэнчээр зүтгэж ирсэн бөгөөд Мерси Кор Монгол байгууллагад ажиллаж байсан 300 гаруй хүнд гүн талархал илэрхийлье.

Эдгээр он жилүүдэд хувийн хэвшил, иргэний нийгэм болон төрийн байгууллагуудтай бүх түвшинд түншилж хамтран ажилласанд бид маш их баяртай байгаа билээ. Хэдийгээр бид үйл ажиллагаагаа өндөрлөж байгаа ч Монгол улс улам мандан бадрана гэдэгт бид бүрэн итгэлтэй байна.

ХОЛБОО БАРИХ

АЛАН ГЛАЗГОУ

Бүсийн захирал | Мерси Кор Ази
aglasgow@mercy Corps.org

ЭРИК МАНДЕЛЛ

Хөтөлбөрийн ажилтан | Мерси Кор Ази
emandell@mercy Corps.org

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

info@mercy Corps.org

МЕРСИ КОРЫН ТУХАЙ

Мерси Кор нь дэлхий ертөнцийг сайжруулан өөрчлөх боломжтой гэдэгт итгэдэг олон улсын байгууллага юм. Бид 40 гаруй улс оронд зоригтой шийдлүүдийг хэрэгжүүлснээр хүмүүст бэрхшээлийг даван туулах, хөгжихөд нь тусалдаг.



Фото: Мерси Корын 2021



45 SW Анкены гудамж
Портланд, Орегон 97204
888.842.0842

mercy Corps.org

RECOMMENDED CITATION: Craft, T., Guyot, W., Hogg, D., Ghorkmayzan, M. (2021) The Legacy of Mercy Corps' Mongolia. Вашингтон хот: Мерси Кор.

Дизайн графикыг Хедер Каммингс боловсруулсан, toohc.com

© 2018 Мерси Корын